

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2009/3 (29)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
Жил 4 удаа хэвлэгдэнэ.  
8 дахь жилдээ

**ᠨᠢᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ**

Д.Солонго Ерөнхий редактор /ХЭҮК-ын дарга/  
Ц.Адъяахишиг Нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах референт/

**ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ:**

- Ж.Амарсанаа /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн/
- С.Нарангэрэл /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, МУИС-ын ХЗС-ийн захирал/
- Л.Баасан /Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, ОТИС-ийн дэд захирал/
- Н.Мөнхбат /НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хүний  
эрхийн шинжээч/
- Л.Мөнхцэцэг /ХЗДХЯ-ны ХЭХҮХ-ийн Ажлын албаны дарга/  
Р.Оюунцэцэг /Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш,  
докторант/

**ᠨᠢᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ**  
**ᠴᠢ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠢᠨᠨᠢᠨ**

ᠠᠠᠨᠠᠭᠤᠨ

Б.Батцэцэг

ᠨᠠᠭᠤᠨ ᠵᠢᠨᠡᠭᠡᠭᠡᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠵᠢᠨᠡᠭᠡᠭᠡᠨ ᠶᠤᠨᠤᠨ  
ᠡᠭᠡᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ  
ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

3

Б.Дэлгэрмаа

ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

16

Х.Мөнхзул

“ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ” ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ  
ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

25

Ц.Одгэрэл

“ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ” ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ  
ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

35

С.Өнөр

ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

46

Ж.Хулан

ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

54

М.Цолмон

ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

62

Э.Энхжаргал

ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

71

ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ ᠶᠤᠨᠤᠨ

Хүний эрхийн нэр томъёоны тайлбар 79

ᠤᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ  
ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ  
ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ



ᠠ.ᠠᠭᠠᠭᠤᠶ᠋ᠠᠶ᠋ᠠ  
ᠵᠢᠨᠨᠠᠭ ᠵᠢᠨᠨᠠᠭ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бүхий л хүрээнд хангах, хамгаалахад чиглэгдсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61/106 дугаар тогтоолоор баталж, 2008 оны 4 сарын 3-ны өдөр 20 дахь улс баталснаар Конвенцийн 45 дугаар зүйлд заасны дагуу мөн оны 5 сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн билээ.

Дэлхийн 143 орон гарын үсэг зурж, 70 орон соёрхон баталсан уг конвенцийг, нэмэлт протоколын хамт Монгол Улс 2008 оны 12 сарын 19-ны өдөр соёрхон баталж, 2009 оны 5 сарын 3-ны өдөр НҮБ албан ёсоор бүртгэснээр Монгол Улсад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн оролцоог хүлээн зөвшөөрч, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцуулах, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх гээд хүний эдлэх ёстой бүхий л эрхийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр үр дүнтэй, далайцтай үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх үүргийг хүлээгээд байна.

Иймд энэ удаа манай улсын хамгийн сүүлд соёрхон баталсан олон улсын баримт бичиг болох Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн дагуу манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг хангаж, сахин хамгаалах талаар ямар үүрэг

хүлээсэн, ийнхүү хүлээсэн үүргээ хангалттайгаар хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллах ёстой талаарх саналаа хуваалцахыг хүслээ.

1. **ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ**

“ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ ᠤ ᠶᠡᠭᠡ ᠶᠢᠨᠨᠠᠭ”

Түүхийн тодорхой үеүдэд бидний одоогийн хэрэглэж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээл гэх нэр томъёо хүний эрхэд суурилсан байдлаар өөрчлөгдсөөр ирсэн.

Улс орнууд “Хандикап”<sup>1</sup>, “Инвалид”<sup>2</sup>, “Импейрмент”<sup>3</sup> гэх нэр томъёог хэрэглэж байгаад Disabled person /монгол хэлээр үгчилбэл “чадваргүй хүн”/ гэх нэршлийг 2006 оныг хүртэл буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц батлагдтал хэрэглэж ирсэн.

Конвенцийн төслийг хэлэлцэх явцад улс орнууд дээрх нэршил нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалтад өртөх шалтгаан болж буйг хүлээн зөвшөөрч Disabled person гэх нэр томъёог “Persons with disability” гэх /монгол хэлээр үгчилбэл “чадвар алдалттай хүмүүс”/ хүний эрхэд суурилсан шинэ нэр томъёо, ойлголтыг бий болгосон. Уг нэр томъёоны утгыг авч үзвэл эдгээр хүмүүс нь бусад хүмүүстэй харьцуулбал ямар нэгэн байдлаар аль нэг чадвар нь тодорхой хэмжээгээр алдагдсан хүмүүс гэж ойлгож

<sup>1</sup>Handicapped- Hand in cap буюу гуйлга гуйх гэдэг санааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хэн нэгний асаргаанд байгаа, “хүний гарт орсон” хүн гэсэн утга бүхий нэр томъёо юм.

<sup>2</sup>Invalid- өвчтөн, өвчинд шаналсан, сул дорой хүн гэсэн утгатай.

<sup>3</sup>Impairment- Хүний биеийн анатомийн бүтэц, физиологийн үйл ажиллагаа алдагдсан гэсэн утгатай.

болохоор байна. Тодруулбал, урьд өмнө нь хэрэглэж байсан нэр томъёонууд нь эдгээр “хүмүүсийг өвчтэй хүн” байдлаар тодорхойлж байсан бол шинэ нэршил нь бусдаас ялгаатай чадвартай болохыг хүлээн зөвшөөрсөн<sup>4</sup>.

Мөн уг чадвар алдалт хүний амьдралын аль ч үед тохиолдож болох тул дэлхий нийт “эрүүл хүмүүс”, “ жирийн хүмүүс” гэдэг үг хэллэгээс татгалзаж “people who are not yet disabled” буюу үгчилбэл “чадвар алдалттай болоогүй байгаа хүмүүс” гэдэг нэршлийг илүүтэйгээр хэрэглэж байна. Хэдийгээр дэлхий нийт “чадвар алдалттай хүмүүс” гэх шинэ нэр томъёог хэрэглэж байгаа зарим улс орнууд тухайлбал ОХУ<sup>5</sup> одоог хүртэл “Инвалид” гэх нэр томъёог ашиглаж байна.

Манай улсын хувьд ОХУ-ын хууль тогтоомжийн “Инвалид” гэдгийг Монгол хэлээр “Тахир дутуу” гэж орчуулан хэрэглэж байгаад 2004 оноос “Хөгжлийн бэрхшээл” гэх нэршлийг хэрэглэх болсон.

Хэдийгээр тахир дутуу гэдэг үгийг өөрчилсөн нь сайшаалтай ч “Хөгжлийн бэрхшээл” гэх нэр томъёо нь хүний эрхэд суурилсан, тэгш боломж олгосон нэр томъёо мөн эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Учир нь, “Хөгжлийн бэрхшээл” гэдэг үг нь хүнийг бие эрхтэний хөгжлийн хувьд ямар нэгэн бэрхшээлтэй мэтээр ойлгогдож байгаа нь эдгээр иргэдийг ялгаварлан гадуурхалтад өртүүлэх үндэслэл болж байна.

<sup>4</sup>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад хүмүүсийн хийж буй үйлдлийн үр дүн ижил байдаг. Жишээлбэл, тэргэнцэр хэрэглэдэг хүн тэргэнцрийн тусламжтайгаар очихыг хүссэн газартаа хүрч байхад бусад хүмүүс өөрсдөө яваад хүссэн газартаа хүрч чаддаг үр дүн нь аль нь ч адилхан хүссэн газартаа хүрч байна.

<sup>5</sup>Тус улс 2008 оны 9 сарын 24-ний өдөр конвенцид гарын үсэг зурсан.

Иймд уг нэр томъёог дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн “чадвар алдалттай хүн”, “өөр чадвартай хүн” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.

Õ äæèéí áýððó ýýèèéí ò óðàé î èí í í èéò èéí ñº ðº ä  
òàí äèàäüí ò àèààð

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх олон нийтийн ойлголт, чиг хандлагыг 3 байдлаар авч үзэж байжээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэсгээл хүртэх ёстой
2. Эмнэлгийн загвар
3. Нийгмийн загвар

Õ äæèéí áýððó ýýèò ýé ðçì ççñáí è äýñäýýè ðçððò ýð, ñð í é

18 дугаар зууны сүүлч хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрвөл түүнийг голд живүүлж алах, ууланд аваачиж хотын гадна орших зэргээр амь насыг нь хохироодог байсан бол урьд байсан номлолын дагуу Христийн шашинд хөгжлийн бэрхшээлтэй /эрэмдэг, зэрэмдэг/ хүмүүс бурханы ивээлд багтах боломжгүй гэж үздэг, Буддын шашинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол урд насандаа нүгэл үйлдсэн тул энэ төрөлдөө гэсгээл хүртэж байгаа гэж номлодог байжээ.

Ýí í ýèäèéí çàäààð

НҮБ байгуулагдсанаар дэлхийн улс орнуудын хүний эрхийн соёл төлөвших гол хөшүүрэг болсон бөгөөд энэ үеэс хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илт үгүйсгэх үзэл санаа арилсан гэж хэлж болох хэдий ч тэднийг эмнэлгийн үйлчилгээ хүртэгч, нийгмийн амьдралд бие даан оролцох боломжгүй өрөвдмөөр хүмүүс мэтээр тодорхойлж, хандсаар ирсэн.

...Áèà ì àðáí äü, í þ óí ñàí àà, ñýò äýè  
ì ýäðýè, ì ýäðýðçéí ñí äí äèéí óèì ààñ  
áóñáúí ààèè í èéäí èéí ðàðèèðààí ä  
í ðí èðí ð -ààààð í ü áçðýí áí èí í 12  
ñàðààñ äýýø òóààòààààð  
ðýçààððèààñáí òçí èéä ò° äæèèéí  
áýððø ýýèò ýé” äýæí èéäí í í .

Хөгжлийн бэрхшээлтэй хүний  
нийгмийн хамгааллын тухай хуулиас

Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг зөвхөн эрүүл мэндийнх нь улмаас бусад хүнээс “дутуу” байдлаар тодорхойлж, тухайн хүнийг бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход саад учруулж буй бусад хүчин зүйлийг тооцдоггүй байна.

Í èéäí èéí çààààð

Нийгмийн амьдрал хөгжихийн хэрээр техник, технологи хөгжиж, олон нийтийн хүний эрхийн ойлголтод ч мөн өөрчлөлт орж эхэлсэн. Үүний нэг тод илрэл нь хөгжлийн бэрхшээлийг дан ганц хүний эрүүл мэндийн байдал бус тэрхүү эрүүл мэндийн байдал нь хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход саад учруулж буй нийгмийн хүчин зүйлтэй нэгдэн нийлсний улмаас үүсдэг хүлээн зөвшөөрч буй явдал юм.

Õ° äæèèéí áýððø ýýèò ýé òçí äýäýäò  
áèà ì àðáí äü, í þ óí ñàí àà, ñýò äýè  
ì ýäðýè, ì ýäðýðçéí áàéí äúí ñí äí äò í é  
á° ä° ä òä ñí äí ä í ü áóñàä ò ° ðèèéí  
áýððø ýýèò ýé í ýäýýí í èéèñí èé óèì ààñ  
áóñáúí í ýäýí ààèè í èéäí èéí  
àì üäðàèä áçðýí äççðýí, çð äçí ò ýé  
í ðí èðí òí ä í ü ñààä ò-ðóóèàðóéò  
áí èñí í ýò äýýäèèä ðýèí ý.

Конвенцийн 1 дүгээр зүйл

Нийгмийн загвар нь хүний эрхийн ойлголтод суурилсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хувь хүнийх нь үүднээс хүлээн зөвшөөрч, нэр төрийг нь хүндэтгэхэд чиглэсэн чиг хандлага юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн үзэл санаа нь ч мөн дээрх нийгмийн загвар хандлагад суурилснаараа ихээхэн ач холбогдолтой. Иймд конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нэг талаас олон жилийн турш хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмнэлгийн загвар

Õ° äæèèéí áýððø ýýè äýäýä í ü  
°° ð-è° ää°í ðóáüñàæáàéäääí ééäí èð  
á° ä° ä í èéäí èéí àì üäðàèä áóñäüí  
í ýäýí ääèè áçðýí äççðýí ÷°è°ò ýé  
í ðí èõí õí ä ñàää ò í ò äí ð  
ó-ðóóèàðóéö áèä ýððò í èé ñí äí ä,  
í èéäí èéí ðäí äèäüí äí èí í ð-í ü  
õýçäààðèäèð ààñ ççäýí áèè äí èæ  
ääéääà äýäèèä ðçèýýí ç°äø °° ðí °.

Конвенцийн удиртгал хэсгээс

хандлагаар авч үздэг олон нийтийн сөрөг хандлагыг өөрчлөх, нөгөө талаас өөрсдийн эрхийг хязгаарласан нийгмийн амьдрал, олон нийтийн сөрөг чиг хандлагад дасан зохицсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь хандлагыг өөрчлөх нь нэн чухал юм.

**Ì ýäèýä, í ééä èðü ääýýø èççèýõ**

**1. Оролцогч улсууд нь дараахь үр дүнтэй, холбогдох арга хэмжээг нэн түрүүн авах үүрэгтэй:**

a) ð° äæèèéí áýððø ýýèð ýé ðçí ççñèéí ò àèààððè ì ýäèýä í ééäí èð ü ä í èéäí èéí áçð ðçðýý, ýèäí äóýà äýð áçèèéí ðçðýýí ä í ýí ýääççèýõ, ð° äæèèéí áýððø ýýèð ýé ðçí èè í ýð ò °ð, í àí àèí ÷äí àðüä ðçí äýò äýð ýääèü ä áýðæççèýõ;

b) àì üäðàèüí áçð çä ø àò àí ä ð° äæèèéí áýððø ýýèð ýé ðçí èé ðóáüä õí ð óðø èäò àé, õí ðèðí è ó-ðóóèàðóéö, ýèäí äóýà í àñ, ðçèñ çýðýäò çí äýñèýñýí ääääè çóðø èü ä áèè äí èäí ðóéö í èéäýí ä ò í äò ñí í õýä ì àýäò àé ò ýí õýõ;

c) ð° äæèèéí áýððø ýýèð ýé ðçí èè ÷ääääðè, ò ýäí èè í ðóóèæ áóé ðóáü í ýí ðèéí ò àèààððè ì ýäèýä í ééäí èð ü ä í ýí ýääççèýõ.





**2. Èí í áái öèéäöýöyææççëýöyä øø ðèéí áí èí í øø ðèéí áóñ  
áàèäóóèèääóóäü í òàì öü í àæèèèääà**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар аливаа үйл ажиллагаанд өөрсдийнхөө амьдралын “хамгийн сайн шинжээч” болсон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний төлөөллийн санаа бодлыг сонсож, тэднийг орлцуулах боломж олгосноороо уг конвенцийн бас нэг давуу тал юм.

Ýí ýðçç èí í áái öèéä öýðyææççëýöyä ÷èäëýñýí óóóëü ò í äò í í æ, áí äèí äí ø° ò° èá° ðèéä áí èí äñðóóèæ ì° ðä° ð, ø° äæèèéí áýððø ýýèð ýé ðçì ççñò ýé ðí èáí í ò í é áóñàä ø èèäáýðèéä ääðäàðäàà í ðí èðí ä÷ òèñóóä ø° äæèèéí áýððø ýýèð ýé ðçì ççñ, ò ççí èé äí ò í ð ø° äæèèéí áýððø ýýèð ýé ðçìäççäò ýé ç° äè° èä° ð á° ä° ä ò ýái èéä ò° è° è° ð áàèäóóèèääàð ääì æóóèái ò ýái èéä èäýäðò ýé í ðí èðóóéí à.

Конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.3

Өмнө нь дурдсанчлан уг конвенцийн үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхойлох “нийгмийн модел”-д суурилсан тул улс орнууд үүргээ биелүүлэхээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхэн тэдгээр иргэдийн оролцоонд тулгуурласан байх нь зайлшгүй чухал болно. Ингэхийн тулд төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхаж буй байдлыг нэн даруй таслан зогсоох,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр гарч буй хууль тогтоомж бодлого хөтөлбөрт тэдний оролцоог хангаж, санаа бодлыг нь сонсох, тэдгээрийг тусгах,

• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хүний эрхэд суурилсан үнэн зөв, статистик мэдээллийн сантай болох, эрхийн хэрэгжилтэд мониторинг хийх,

*Õ ææèéí áýððò ýé òçí èéã ýèãããàððèàí ãããóóððàæáóé áàéèù ã í ýí ààðóé ò àñèàí çí ãñí í õ.*

Хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд нь улс орны эдийн засгийн хүчин чадалтай уялдаа холбоотойгоор хэрэгждэг тул конвенцид нэгдэн орсон, соёрхон баталсан ядуу буурай орнуудын хувьд эдгээр эрхийн хэрэгжилтийг нэн дэрүй хангах боломж байдаггүй. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн заалтын дагуу улс орнууд өөрийн боломжоо дээд зэргээр ашиглаж, аажмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах үүрэг хүлээж байна. Ийнхүү хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд улс хоорондын хамтын ажиллагаа, олон улсын донор байгууллагуудын туслалцаа дэмжлэгийг ашиглаж болохыг мөн тусгасан байдаг.

*Ýàèéí çàñàã, í èéãýì , ñí , èý í ýððèéí ò óðàéã ýããýýð ýððèéã áçðýí äççðýí ýãèççýõ í °ð°è áàéèù ã ààæì ààð áéé áí èãí õ ççáí ýýñ í ðí èõí ã- óèñ áçð í èí í óèñí í ýðð ççéí ãããóó í ýí ààðóé ççñýõ ýí ýðçç èí í ááí õí ð ðçýýýèýñýí ççðýãò ýé çè òàðð èàð áàéèèààð °ðèéí áí èí í æèð í °°ðèéã äýýä õýí æýýãýýð àð èãèàð á°ã°ã ò ààðàèàãàò áé ò í ðèí èãí èã í èí í óèñí í ðàí ò ù í àæèéèããàí á ò çð èãèýí ý.*

Конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.2

Харин улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчиж

байгаа аливаа зөрчлийг нэн даруй таслан зогсоох үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүй тохиодолд тухайн иргэн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй юм.

*Õ ãæèéí áýððà ýýèò ýé ð¿ì ¿¿ñèéí ýððèéí ÷èèýèýýýð ãàð- áóé ðóóéü ò í ãð î î ì æáí äèí áí ò° ò éá° ðò ò ýáí èé í ðí èõí î ã òàí äãæ ñàí àà áí äèü ä í ü ñí í ñí æ ò ýäýýðèéä ò òñããð,*

Олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон, соёрхон баталсан улс орнуудын шийдвэр гаргагч нарын эн түргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ олон улсын гэрээний зохицуулалтад үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх юм. Энэ нь тухайн гэрээний заалтаас шууд иш татах, шинэ хууль тогтоомж батлан гаргах, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоо олон улсын гэрээний үзэл санаад нь нийцүүлж нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр хийгдэж болох бөгөөд чухам ямар аргаар хэрхэн нийцүүлэх нь тухай олон улсын баримт бичгээр улс орнуудад чиглэмж өгсөн эсэх, эсхүл тусгайлсан зохицуулалттай зэргээс ихээхэн хамааралтай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь дээрх 2 шинжийг аль алийг нь агуулсан тул бид ямар аргыг хэрэглэх нь илүү амжилтанд хүрэх талаар сонголт хийх боломжтой юм. Харин энэ мэт шийдвэр гаргах үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагуудын саналыг сонсч, хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр боловсруулахад тэдний оролцоог хангах нь чухал.

Бусад олон улсын баримт бичгүүдээс давуу талтай нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид аливаа шийдвэр гаргалт, тоон мэдээ, мэдээлэл цуглуулахад тэдний



19 i añi ù òai ýçýæááéí à āyæäçāi ýñýi áàéōāā, 2003 í í ä Áí éi añóí è, Ñí, è, Ø èi æýō Óōāàí ù ßài í ù āàðāāñàí ñò àò èñò èé ì ýäýýéýä 37000 ò āæéééí áýðð ýýèò ýé òççðýä ááéí à āyæý. Ì °í í í ä Óèñù í Óàèàì æèéí Ààçðāāñ 34000 ò āæéééí áýðð ýýèò ýé òççðýä ááéí à āyñýi áçðò āýé ñóāāéāāā āàðāāñàí ááéí à.

2007 оны Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэлээс

Дээрх тоо баримт нь зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээ авч буй, шаардлагатай тэтгэвэр тэтгэмж авч буй хүмүүсийн талаарх тоон мэдээлэл /эмнэлгийн загвар/-д тулгуурласан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн үзэл санаа нь бүхэлдээ хүний эрхэд суурилсан шинэ чиг хандлагад тулгуурласан тул статистик тоон мэдээлэл нь эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн тооноос гадна тэдгээр хүмүүсийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход саад учруулж буй хүндрэл бэрхшээл, ялгаварлан гадуурхалт, тэгш бус боломжийн талаарх мэдээллүүд дээр үндэслэгдсэн байх ёстой. Гэтэл манай улсад одоогоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэж буй хүмүүсийн тооноос өөр судлагаа мэдээлэл гараагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахад чиглэсэн аливаа бодлого, хөтөлбөр, хууль тогтоомж баталж, хэрэгжүүлэхэд эн тэргүүнд тухайн баримт бичгийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг статистик мэдээлэлд тулгуурлан гаргаж ирэх шаардлагатай байдаг. Гэтэл дээр дурдсанчлан Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа хол зөрүүтэй байхад тэдгээр иргэдийн эрхийг хамгаалах, хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөр хууль, тогтоомж нь “ нүдээ олсон” байх боломжгүй юм.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хүний эрхэд суурилсан мэдээлэл, статистик баримт цуглуулж, үүнд үндэслэсэн бодлого хөтөлбөр боловсруулах нь нэн чухал ба мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг төрийн байгууллагаар хязгаарлалгүй төрийн бус байгууллагуудыг оролцуулж, хамтран ажиллавал илүү амжилттай үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

ᠮᠤᠩᠭ᠋ᠢ ᠵᠡᠪᠡᠲᠦ: ᠴᠠᠳᠠ ᠨᠣᠳᠣ᠋ᠠᠢᠶ᠋ᠨᠪᠦᠬᠦᠬᠦᠳᠡᠬᠦ ᠠᠵᠢ ᠨᠠᠵᠤᠯᠠᠭᠤ, ᠶ᠋ᠢᠭᠦᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ



**ᠠᠶᠠᠶᠠᠶᠠᠳᠢ ᠠᠵᠢ  
ᠨᠠᠵᠤᠯᠠᠭᠤ-ᠶ᠋ᠢᠨ ᠠᠵᠢᠨ, ᠨᠣᠳᠣ᠋ᠠᠢᠶ᠋ᠨ ᠵᠠᠳᠠ ᠠᠵᠢᠨ**

2007 оны байдлаар манай улсын 14-өөс доош насны хүүхдүүд 752,8 мянга байсан бөгөөд энэ нь нийт хүн амын 28 хувийг эзэлж байгаа юм. Харин 15-19 хүртэлх насны хүүхдүүдийг нэмбэл 1 сая 61 мянга буюу нийт хүн амын 40 хувийг эзэлдэг гэсэн тооцоо гарч байна. Нийгмийн нэг хэсгийг бүрэлдүүлэгч эдгээр хүүхдүүд нь ирээдүйн том хүмүүс, ирээдүйн хэрэглэгч нар төдийгүй өнөөгийн зах зээл болон зар сурталчилгааны идэш, олз юм. Учир нь дэлхийн зар сурталчилгааны мэргэжилтнүүд хүмүүсийн сэтгэлд шинэ хүсэл хэрэгцээг зальжин аргаар бий болгохын тулд жилд хэдэн зуун тэрбум долларыг гарынхаа салаагаар урсгаж, цацаж байдаг байна. Энэ үйл ажиллагааныхаа хүрээнд тэд олон улсын хүүхдийн зах зээлд ихээхэн ач холбогдол тавьдаг төдийгүй тэдний хувьд хүүхдүүд бол хамгийн амархан тархийг нь угааж болох бай болдог ажээ.

**ᠨᠠᠵᠤᠯᠠᠭᠤ ᠠᠵᠢᠨ ᠠᠵᠢᠨ ᠠᠵᠢᠨ**

Зар сурталчилгааны мэргэжилтнүүд тодорхой нэг брэндэд хэрэглэгчдийн үнэнч байх хандлага болон хэрэглэгчдийн зан төлөв нь хүүхэд байх үеэс бүрэлдэн тогтсоор насанд хүрэхэд төлөвшдөг гэдэгтэй санал нийлдэг ажээ. Иймээс эцэг эхчүүд болон маркетерүүд хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн болон үйлчилгээг



сурталчлах эрхийн талаар хэдийнээ сэтгэл зовниж, санаа тавьж эхэлжээ. Тухайлбал: Хятад улс зар сурталчилгаанд мөнгө зарцуулах тал дээр Америк, Японы араас дэлхийд гуравдугаар байрт ордог ба тэдний хүн амын бодлого нь өөрсдийг нь сэтгэл зовнихоос аргагүй байдалд хүргэдэг байна. 1979 онд коммунист Хятадын хүн амын өсөлтийг хязгаарлахын тулд явуулсан Хятадын удирдагч Дэнг Сиопингийн нэг хүүхдийн бодлогыг эс тооцон Хятадад нэг жилд ойролцоогоор 23 сая буюу бараг Малайзын нийт хүн амын тоотой тэнцүү хэмжээний хүүхэд шинээр мэндэлдэг аж. Эдгээр хүүхдүүдийг зарим нэг талаар бяцхан хаад, хатад гэж нэрлэж болох талтай. Учир нь тэдний эцэг, эх болон эмээ, өвөө нар нь тэдэнд маш их анхаарал хандуулж, бараг хүссэн бүхнийг нь авч өгдөг байна. Зөвхөн Хятадын том, том хотуудад л гэхэд эцэг эхчүүд хүүхдийнхээ хүслийг биелүүлэхийн тулд жилд дунджаар 3 тэрбум америк доллараас илүү их хэмжээний мөнгийг зарцуулж байна гэсэн мэдээ бий. Тэдгээр хүүхдүүд эцэг эхийнхээ гаргаж буй нийт зардлын 68 хувийг тодорхойлж буй нь магадгүй дэлхий дээрх хамгийн хүчтэй рекламны нөлөөлөл байж болох юм<sup>1</sup>. Энэ нь манай улсын хувьд харьцуулшгүй тоо баримт боловч сэтгэл зовнихгүй байж болох асуудал биш юм. Бид өнөөдөр мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Хүүхдүүд тэдгээр мэдээллийг ойлгож, ялгах чадвартай юу гээд олон асуудал урган гардаг. Нэлээн хэдэн долоо хоногийн өмнө миний охин хурууныхаа завсар харандаа хавчуулчихаад, амандаа нэг сорон гадагш үлээх үйлдэл хийж байсныг би тодхон санаж байна. Магадгүй та гэртээ тамхи татдаг хүнтэй л юм байна даа гэж бодох байх... Манай гэр бүлийн хүрээнд бүү хэл эргэн тойронд тамхи татдаг хүн нэгээхэн ч үгүй билээ. Тэгээд, яагаад гэдэг асуудал үүсэх нь гарцаагүй. Та бүхэн санаж байна уу. Нэгэн олон улсын байгууллагын захиалгаар хийсэн сурталчилгаанд том

<sup>1</sup> /Young consumers/ vol.8 no.2.2007.pp 154-156, Candice Liu,Robin Teow and Belinda Tang, Is advertising becoming child's play in China?

хүн таны хийсэн үйлдэл бүхнийг хүүхэд тань дуурайна шүү хэмээн сэрэмжлүүлэг өгөх санаагаар ээж нь нүүрээ будахаар охин нь нүүрээ будаж, аав нь тамхи татахаар хүү нь тамхи татдаг.... Том хүн та магадгүй үүнийг ойлгох биз, харин 3 настай хүүхэд үүнийг хэрхэн ойлгох бол ..... Тэд энэ чинь аавынхаа, ээжийнхээ хийж буй буруу үйлдлийг хүүхэд нь даган дуурайж болох учраас аав, ээжийг минь буруу үйлдэл бүү хийгээсэй гэж байна хэмээн ойлгох болов уу. Хүүхэд нас гэдэг бол хамгийн үнэт нандин цаг үе байдаг ба энэ үеийг нь сүйтгэн оюун ухаанд нь дайралт хийх нь байж боломгүй зүйл юм. Бас нэгэн нэртэй компанийн рекламанд ээжийнхээ даашинзыг охин нь хайчлаад өмсчихдөг... би лав охиндоо ийм рекламыг үзүүлэхгүй ээ хэмээн ярьж байсан олон ээжийг би мэднэ. Тэр реклам нь хүүхдэд хэрхэн нөлөөлж болохыг реклам бүтээгчид төдийлөн анхаарахгүй байна. Хүүхдийн гэнэн цагаан сэтгэлийг иймэрхүү зүйлд ашиглах нь буруу юм. Зар сурталчилгаа бол хүүхдүүдийн амьдралыг харах өнцгийг өөрчлөн гуйвуулж байгаа хортой зүйл гэж хэлж болох талтай болжээ. Хүүхэд бүр ухаалаг, цагаан, цэвэрхэн цаас шиг төрдөг хэмээдэг. Гэвч бидний нийгэм тэднийг хог новшоор дүүргэдэг. Хүүхэд өөрөө өөртэйгээ байх илүү их эрхтэй. Тусгаар байдал хэрэгтэй боловч эцэг, эх нь тийм бололцоог олгодоггүй. Дээр нь зурагт, реклам, зар сурталчилгаа. ...

3-7 настай хүүхэд зар сурталчилгааг бусад нэвтрүүлгээс таньж, ялгаж эхэлдэг ба тэдэнд хөгжилтэй, сонирхолтой, итгэл төрүүлэхүйц санагддаг байна. 7-11 настай хүүхдүүдийн хувьд зар сурталчилгаа нь ятгах оролдлогыг хийж буйг мэдэрдэг. 11-16 насны хүүхдүүдэд итгүүлэх оролдлогыг хийж буй нь мэдрэгдэхийн сацуу өдөөлт, сэдэл, тэмүүлэх хандлагыг төрүүлж байдаг байна.<sup>2</sup> Тэд ихэнхдээ зар сурталчилгааг зугаатай, үнэн бодит, мэдээллийн үр өгөөжтэй зүйл

<sup>2</sup> Journal of consumer research.,pp 204,

хэмээн боддог. Цаашлаад зарим мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар иймэрхүү төрлийн зүйлсийг хүүхдүүд одоохондоо өөрсдөө шүүн тунгаан, мэдрэмжтэйгээр хүлээн авах чадвар бараг байдаггүй ажээ. Хүүхэд төдийгүй зарим насанд хүрэгчид хүртэл хүчтэй зар сурталчилгаанд автан, ялган боловсруулах чадвараа алдах нь байдаг шүү дээ.

**ᠴᠠᠳᠤ ᠰᠤᠷ ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠭᠠᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ “ᠴᠠᠷ ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠭᠠᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ” ᠪᠣᠯᠣᠨ “ᠬᠡᠭᠦᠬᠦᠳᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠨᠢᠬᠡ ᠮᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ” ᠬᠡᠭᠣᠯᠠᠭᠤᠨ ᠵᠡᠮᠤ ᠴᠠᠷ ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠭᠠᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠡᠭᠣᠯᠠᠭᠤᠨ**

Монгол Улсад хүүхдийн зар сурталчилгаатай холбоотой гол эрх зүйн зохицуулалт нь “Зар сурталчилгааны тухай” болон “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай ” хуулиуд юм. Зар сурталчилгааны тухай хуульд буй хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалтын ерөнхий зарчмуудын дагуу зар сурталчилгаа нь эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулахгүй байх, тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг эцэг, эх болон бусад этгээдээс шаардахыг хүүхдэд шууд зөвлөх, ухуулах, бусад хэлбэрээр нөлөөлөхгүй байх, хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглахгүй байх ёстой. Түүнчлэн тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, дадлага, туршлагын төвшинг бууруулж буюу өсгөж сурталчлахгүй байх, бүтээгдэхүүний үнийн талаар хүүхдэд буруу ойлголт бий болгохыг хориглодог байна. Зар сурталчилгааны хуулийн нэгэн нарийвчилсан заалт нь хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болохыг тусгасан байдаг. Дээрхи ерөнхий шаардлагууд зөрчигдөх тохиолдлууд амьдрал дээр илэрсээр байна. Тухайлбал: нэгэн шоколадны рекламанд ... “хүүхдүүдээ аав, ээждээ захихаа мартаваа” хэмээн мөн өөр нэгэнд ...“танай хүүхэд амжилтанд хүрэх болно”, “миний эцэг, эх надад хамгаас илүү хайртай” гэх зэргээр эцэг, эхийг нь авч өгөхөөс өөр аргагүй байдалд

хүргэсэн байдаг. Түүнчлэн нэгэн бяцхан охины хожуулан ойд зогсоод сэтгэл сэрдхиймээр уйлах чимээ.. гардаг реклам гээд дурдвал нэлээн олон жишээ гарах бий.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар хүүхдэд үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулах, терроризм болон бусад гэмт хэрэг, садар самуун, хүчирхийллийг сурталчлах, түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд өөрөө хүсээгүй бол хүүхдийг сурталчилгаанд ашиглахыг хориглодог. Мөн түүнчлэн өөрийнх нь болон эцэг, эх, асран хамаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг мэдээлэл сурталчилгаанд ашигласан, бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах тоглоом, наадамд оролцуулах үйл ажиллагаа явуулсан иргэн, албан тушаалтны олсон ашиг, орлогыг хурааж, 30000-60000 төгрөгөөр торгохоор заасан байдаг. Энэ хүрээнд хүүхдүүдийн оролцон тоглосон рекламыг нэгэн адил ойлгох болов уу. Тухайлбал: Нэгэн хүүхдийн живхний рекламанд бяцхан жаалыг жорлон цэвэрлэгч болгосон байдаг. Эгдүүтэй бас хөөрхөн л дөө. Гэхдээ хүүхдүүдээ рекламанд л тоглож байвал юунд ч хамаагүй тоглуулах гээд байдаг нь эцэг, эхчүүд бидний бодлогогүй алдаа юм.

Зар сурталчилгааны болон хүүхдийн эрхийн тухай хуулиар хуульчилж өгсөн дээрх заалтууд нь хэт ерөнхий бөгөөд зарим нэг чухал харилцаанууд орхигдон зохицуулаагүй байгаа нь ажиглагдаж байна.

**ᠠᠭᠤᠨᠠᠭᠤᠨ ᠠ ᠳᠡᠨ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠵᠡᠭᠦᠨ ᠪᠢᠴᠦᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ ᠶᠡᠨᠳᠡᠨ ᠶᠢᠨᠮᠡᠰᠡᠷ**

Европын Холбоонд элсэхдээ Польш улс нь хууль тогтоомжоо Европын Холбооны хууль зүйн жишигт нийцүүлэх зорилгыг тавьж

маш олон эрх зүйн актдаа нэмэлт, өөрчлөлт хийсний нэг нь Зар сурталчилгааны хууль төдийгүй хүүхдэд зориулсан зар сурталчилгааны хууль юм. Дээрхи хуулийн ерөнхий заалтын дагуу зар сурталчилгаа нь насанд хүрээгүйчүүдийг тухайн сурталчилж буй барааг шууд худалдан авахыг уриалаагүй, түүнчлэн худалдаж авахаар эцэг, эхээ шахамдуулах нөхцөл үүсгэхээргүй байх ёстой. Түүнчлэн рекламанд эцэг, эх болон багш, насанд хүрээгүйчүүдийн итгэл хүндэтгэлийг хүлээдэг хүнийг ашиглаж болохгүй. Мөн зар сурталчилгаанд насанд хүрээгүйчүүдийг тодорхой зорилгогүйгээр аюултай, гаж орчинд буйгаар харуулахыг хориглодог. Зар сурталчилгаа нь сэтгэцийн, ёс суртахууны хөгжилд саад болох ёсгүй буюу нэн ялангуяа хүүхдэд зориулсан хөтөлбөрийн дундуур реклам цацахыг хориглодог байна. Мөн дээр нь нэмээд хэлэхэд хүүхдэд зориулсан зар сурталчилгаанд уг сурталчилгааг цацагдахаас гурван сарын дотор хүүхдэд зориулсан болон мэдээллийн хөтөлбөрт оролцож байсан хүний дуу хоолой болон зургийг ашиглахыг хориглодог ажээ.

Үүнээс гадна нарийвчилсан зарим нэг зохицуулалтыг авч үзье. Польшийн тамхины хэрэглээнээс нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд хүүхдэд хүрч болох бүх төрлийн медиа, сурталчилгааны хэрэгсэлд (телевиз, радио, сургууль болон бусад боловсролын байгууллага, хүүхэд залуучуудын хэвлэл, спортын дугуйлан болон бусад олон нийтийн газар) тамхитай холбоотой зар сурталчилгааг бүрэн хориглодог бол согтууруулах ундааны хувьд тамхитай бараг адил хэдий боловч хэрэглэгдэх хүрээ нь ялгаатай. Учир нь залуучуудад л хандаагүй бол шар айрагны сурталчилгааг цацахыг зөвшөөрдөг байна. Гэхдээ ийм төрлийн зар сурталчилгааг өглөөний 6 цагаас оройн 8 цаг хүртэл хугацаанд радио, телевиз, театр, видео кассет болон хүүхэд залуучуудын хэвлэлд цацахыг хориглодог ба зурагт хуудас, хөдөлгөөнт болон үл хөдөлгөөнт зар сурталчилгааны 20 %-д нь хор хөнөөлийнх нь талаар харуулж нэмж

”насанд хүрээгүйчүүдэд согтууруулах ундаа зарах нь гэмт хэрэг” гэж бичихийг шаарддаг юм. Хүүхдэд зориулагдсан, эсвэл хүүхдэд зориулагдсан байж болохуйц аливаа элемент агуулсан л бол эм тарианы зар сурталчилгааг хориглохын сацуу хүүхдэд зориулсан хөтөлбөр явагдахаас өмнөх болон дараах 20 минутанд эл төрлийн зар сурталчилгаа явуулахыг хориглодог байна.<sup>3</sup>

Швейцар нь Европын Холбооны гишүүн орон биш учраас Европын хуулийг шууд даган мөрддөггүй боловч тэдгээр нь чухал нөлөөлөл үзүүлж байдаг байна. Швейцарьд зар сурталчилгааны харилцааг зохицуулдаг гол хууль нь Шударга бус өрсөлдөөний эсрэг Холбооны тухай хууль бөгөөд энэхүү хуулиар шударга бус болон буруу зан авир, хуурмаг эсвэл шударга байх зарчмыг зөрчсөн бизнес эрхлэхийг хориглосон. Харин Үндсэн хуулиараа хүүхдийн биеийн болон сэтгэцийн, ёс суртахууны хөгжлийг хамгаалдаг ажээ. Гэлээ ч гэсэн Швейцарьд хүүхдэд зориулсан тусгай зар сурталчилгааны тухай хууль байхгүй юм байна. Гэхдээ телевиз болон радиогийн тухай хуулиар хүүхэд болон насанд хүрэгчдэд чиглэсэн зар сурталчилгааны харилцааг зохицуулдаг. Бүх нийтийг хамгаалахын тулд архи, тамхины сурталчилгааг телевизээр цацахыг хориглосон ба харин тамхины сурталчилгааг кино театрт зөвхөн оройн 7–н цагаас хойш 2 кино тутамд нэг байхаар зөвшөөрсөн байна. Архины хувьд үзэгчдийн ихэнх нь хүүхэд биш бол зөвшөөрөгддөг нь ихээхэн хачирхалтай. Мөн нэгэн сонирхол татахуйц зохицуулалт нь 25 наснаас залуу харагдахаар моделиг тамхины сурталчилгаанд тоглуулахгүй байх эс бөгөөс зар сурталчилгааны хэмжээ болон гаргалтын тоог хязгаарладаг байна. Эмийн сурталчилгааг зөвшөөрдөг ба харин хүүхдэд зориулагдсан эмийн хувьд нарийвчилсан

<sup>3</sup> /Young consumers/ vol.8 no.3.2007.pp 219-211, Ewa Skrzydlo-Tefelsko and Eric Rheims, Advertising to children in Poland

зохицуулалт байхгүй. Мөн түүнчлэн ном, хэвлэлийн тухайд залууст зориулагдсан бол архи, тамхины сурталчилгаа хийхийг хориглоно гэснээс өөр заалт байдаггүй юм байна. Ер нь Швейцарьд хүүхдэд зориулагдсан зар сурталчилгаа нь маш чөлөөтэй, ардчилалтай байдаг нь Шударга байх зар сурталчилгааны хорооны үйл ажиллагаатай холбоотой юм байна. Энэхүү хороо нь зар сурталчилгаа нэг бүрийг хянаж, дүрэм зөрчсөнтэй нь хариуцлага тооцож маш нягт нямбай, сайн ажилладаг байгууллага юм. Үүний үр дүнд Швейцарийн шүүхээс зар сурталчилгаатай холбоотой ямар нэгэн үнэлэлт дүгнэлт гардаггүй юм.<sup>4</sup>

Турк улсад хүүхдийн зар сурталчилгаатай холбоотой хууль дүрэм нь “Зар сурталчилгаа болон Зар мэдээтэй холбоотой үйл ажиллагааны талаарх журам” болон “Радио, Телевизийн байгууллагын нэвтрүүлгийн үйл ажиллагааны талаарх дүрэм” юм. Дээрх журмуудад заагдсан ижил заалтуудаас дурдвал: Зар сурталчилгаа цацахад хүүхдийн мэдрэмж, мэдрэхүйг харгалзан үзэх шаардлагатай. Хүүхдийн бие, оюун санаа, сэтгэлзүйн хөгжилд ямарваа нэгэн хор нөлөө учруулах зүйл агуулах ёсгүй. Хүүхдүүд даган дуурайж болохуйц хүчирхийллийн шинжтэй зүйл агуулсан байж болохгүй. Зар сурталчилгаа нь хүүхдүүд худалдан аваад хэрэглэж чадахгүй бараа үйлчилгээг сурталчилж байгаа тохиолдолд хүүхэдтэй холбоотой аливаа мэдээлэл агуулах ёсгүй. Мөн хүүхдийн мэдэхгүй, чадахгүй зүйлийг болон бүрэн бус мэдээлэл агуулаагүй байх ёстой. Тухайн зар сурталчилгаа нь хүүхэд эцэг, эхийгээ болон бусдыг шаналган сурталчилсан бараа үйлчилгээг авахуулахад хүргэх ёсгүй. Зар нь тухайн сурталчлагдсан бараа үйлчилгээний цорын ганц эзэмшигч болсноор нийгэмд эзлэх байр суурь, бие сэтгэлзүйн хувьд

<sup>4</sup>Young consumers/ no.2.2005.pp 80-81, Peter Hofer and Jeannette Bieri, Frick Hofer Hunziker describe the legal environment in Switzerland, Advertising to children in Switzerland

давуу байдал олж авна гэсэн ойлголтыг бий болгох агуулгатай байх ёсгүй. Зар сурталчилгаанууд нь эцэг, эхчүүдийн хүүхдээ гэсэн сэтгэлийг хэт хөөрөгдөж болохгүй ба хүүхдийн гэнэн зан, мэдэхгүй зүйлээр далимдуулан бараа үйлчилгээг сурталчлахыг хориглодог. Хүүхэд жинхэнэ чанарыг нь мэдэхгүй буруугаар ойлгох явдал гарч болзошгүй учир зар сурталчилгаанд бараа үйлчилгээний үнийг нь дурдахгүй байх, айл өрх бүрийн төсөв тухайн бараа үйлчилгээг худалдан авах боломжтой хэмээн тооцох ёсгүй болно. Гэхдээ Туркд хүүхдийн сурталчилгаа нь нарийн боловсруулагдсан мэт боловч амьдрал дээр мөн л байнга зөрчигдөж байдаг байна. Тухайлбал: нэгэн үнэт эдлэлийн компанийн рекламанд хүү нь ээждээ алмазан бөгж авч өгөхийг ааваасаа гуйж буй дүр зураг гардаг байна. Мөн өөр нэгэн морины уралдаанд мөрий тавьдаг сурталчилгаанд 3 жаахан хүүхдийг мөлхүүлж уралдуулдаг бөгөөд аав нар нь бариан дээр тэднийг дэмжин хүлээж буйг дүрсэлсэн байдаг ажээ. Гэхдээ эдгээр хууль бус сурталчилгаануудад тэр даруй арга хэмжээ авсан юм байна. Зар сурталчилгааны зөвлөлөөс баталсан Сурталчилгааны журамд сурталчилгааг цацсан байгууллага, түүнийг захиалагч, зохион бүтээгчид бүгдээрээ хариуцлага хүлээх үүрэгтэй хэмээсэн байдаг.<sup>5</sup>

Монгол оронд хэдийгээр боловсрол болон олон нийтийн мэдээллийн сүлжээний салбарууд эрчимтэй, хурдацтай хөгжиж буй боловч Монгол улсын ирээдүйн залуу, чадамжтай, худалдан авагч нарын сайн сайхан байдлыг дэмжихийн тулд ойрын ирээдүйд хууль тогтоогч нар илүү хатуу, нарийвчилсан зохицуулалтыг тогтоож өгөх нь зүйтэй юм. Тиймгүй бол хүүхдийн зар сурталчилгааг хууль сахиулагчид ч үл тоомсорлон, бидэн шиг эцэг, эхчүүдийн дунд рекламны тухай маргаан оршсоор л, хүүхдүүд рекламны бай болсоор л байх болно.

<sup>5</sup> [www.gala-market-law.com](http://www.gala-market-law.com)



“ᠤ᠋ ᠶ᠋ᠢᠨᠡᠢ ᠶ᠋ᠳᠦ” ᠶ᠋ᠢᠨ ᠤ᠋ᠶ᠋ᠳᠦᠶ᠋ᠢ ᠶ᠋ᠳᠦᠴᠦᠶ᠋ᠢ ᠴᠢᠨ ᠤ᠋ᠶ᠋ᠳᠦᠶ᠋ᠢᠶ᠋ᠳᠦᠶ᠋ᠢ  
ᠶ᠋ᠢᠶ᠋ᠢᠶ᠋ᠢ ᠶ᠋ᠶ᠋ᠢᠶ᠋ᠢ



ᠤ᠋ᠶ᠋ᠢᠨ ᠤ᠋ᠶ᠋ᠳᠦᠶ᠋ᠢ  
ᠤ᠋ᠶ᠋ᠳᠦᠶ᠋ᠢ ᠶ᠋ᠶ᠋ᠢᠶ᠋ᠢ ᠶ᠋ᠶ᠋ᠢᠶ᠋ᠢ

1992 оноос манай оронд хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль тогтоомжоор баталгаажуулах үйл явцтай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн үйл явц эхэлсэн билээ.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээний нэг гол асуудал нь хүний эрх, түүний аюулгүй байдлыг хамгаалах явдал.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, Монгол Улсын Үндсэн хууль зэрэг үндсэн баримт бичгүүдэд хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна<sup>1</sup> гэж заасан.

Хүний эрхийг хамгаалах, хангах чиглэлээр “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”, “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүд батлагдан гарч буй хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй, охид, эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэн үзэх, аливаа хүчирхийллээс ангид байх нь бодит амьдрал дээр төдийлөн

1 ХЭҮК Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа, Улаанбаатар., 2007.

хэрэгжихгүй, эмэгтэйчүүдийг дорд үзэх, ялгаварлан гадуурхах, явдал гарсаар байна.

Үүний нэг илрэл нь хүчиндэх гэмт хэрэг хэрэг бөгөөд улсын хэмжээнд 2009-2010 оны эхний 9 сарын байдлаар 140 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 8.5 хувиар өссөн байна.<sup>2</sup>

Бид зөвхөн хуулийн байгууллагад хандсан, эсвэл шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг хараад л манайд энэ төрлийн гэмт хэргийн гаралт их биш гэж үздэг. Гэвч бүртгэгдсэн нэг хэргийн цаана бүртгэгдээгүй олон хэрэг нийгмийн болон хууль, эрх зүйн таагүй орчноос улбаатайгаар нуугдмал далд хэвээр байгаа нь Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв зэрэг эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хандсан охид, эмэгтэйчүүдийн түүхээс харагддаг.

Энэ хэрэг нь охид, эмэгтэйчүүдийн халдашгүй чөлөөтэй, аюулгүй байх эрхэнд халдсан, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудал төдийгүй хүний бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрх чөлөө, хувийн халдашгүй байдлын эрх, бэлгийн харилцаанд өөрөө хяналт тавих болон удам угсаагаа төрүүлэх эрхийг ч зөрчдөг тул хүний эрхийг дээдэлсэн энэ зуунд хүн төрөлхтөн дэлхий нийтээрээ үүний эсрэг нэгдэн тэмцэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Дэлхий дээр 5 эмэгтэй тутмын 1 нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог тухай статистик тоо баримт байна.<sup>3</sup>

<sup>2</sup> Улсын дээд шүүхийн судалгааны албаны мэдээлэл-2009

<sup>3</sup> ХЭҮК Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа, Улаанбаатар., 2007.

Хүн амын нөхөн үржихүй эрүүл мэндийн түүвэр судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 4 хувь нь амьдралын туршид хүүхэд байхад болон насанд хүрсэн хойноо хэн нэгэнтэй хүсээгүй байхдаа бэлгийн харьцаанд орж байсан гэж хариулсан байна.<sup>4</sup>

Олон улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, бэлгийн хүчирхийллийг бууруулах таслан зогсоох чиглэлээр хэд хэдэн баримт бичиг гарсан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1, 2, 4, 7, дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 8 дугаар зүйлийн 8.2-т “ Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй”, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 2 дугаар зүйлд “Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг буруушаан, эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах бодлогыг зохистой бүхий л аргаар нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээг авах ” зэрэг охид, эмэгтэйчүүдийг хүйсийн болон аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах тодорхой эрхүүдийг дэлхийн нийт хүлээн зөвшөөрдөг.

Мөн Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай болон Эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн тухай олон улсын гэрээнд эмэгтэйчүүд эрүүл саруул байхыг хамгаалсан заалт олон байдаг. Үүнд бие махбодь, сэтгэц нөхөн үржихүй болон бэлгийн эрүүл мэнд ордог.

Эмэгтэйчүүдийг аливаа хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, эмэгтэй хүн хуулийн өмнө тэгш эрх эдлэхийг баталгаажуулах нь олон улсын өмнө төрийн хүлээсэн

<sup>4</sup>Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын Сан, Эрүүл мэндийн яамны хамтарсан судалгаа 2008.

үүрэг бөгөөд олон улсын гэрээ конвенцийн үзэл санааг үндэсний хууль тогтоомжиндоо дараахь байдлаар тусгасан байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “хүн амьд явах эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”, мөн хуулийн 16 зүйлийн 14-д “МУ-ын хууль, ОУ-ын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах,.... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... нотлох баримтыг шалгуулах, ... эрхтэй хэмээн тунхагласан байна.

Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл, УДШ-ийн 1989 оны 10 дугаар сарын 13-ы өдрийн 28-р тогтоолоор батлагдсан тайлбараар хүчиндэх гэмт хэргийг тодорхойлж өгсөн.

Хүчиндэх гэмт хэргийн агуулгыг авч үзвэл:

Эрүүгийн хуулийн агуулга	Улсын дээд шүүхийн тайлбарын агуулга
<p>126.1 <i>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</i>  <b>хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, үнэ цэнийг алдах, эрх, эрх чөлөө, хөрөнгийг эзэмшлээгүй байдлыг үүсгэнэ</b>  <i>áóñáú í áèáú òàì àààèæ ÷àààõāçé áàéáèú ā ààèèì áóóèàí òóðúòàè çéèāñýí áí é ò àāáí æèè òçðò ýè òóāáòāāāāāð õí ðèõ ýè ø eèò āyí ý.</i></p>	<p>Хүчиндэх гэдэг нь: Гэмт этгээд хурьцал үйлдэх өөрийн санаа зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хохирогчийн <b>ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b>, түүний эсэргүүцэл, зоригийг няцааж хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, эсвэл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах замаар хүчирхийлэн хурьцал үйлдэхийг хэлнэ гэжээ.</p> <p><b>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b> гэж үзэх <b>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b> гэмт этгээдийн халдлагын эсрэг <b>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b> <b>ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b> буюу <b>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮᠤᠨᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠰᠤᠶᠢᠯᠢᠨ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ ᠲᠦᠭᠠᠭᠠᠷ</b> байдлыг анхаарвал зохино.</p>

Улс орнуудын хууль тогтоомжинд Хүчиндэх гэмт хэргийн талаарх ойлголт тодорхойлолт нийтлэг, боловч дараах байдлаар ялгаатай тодорхойлогдож байна<sup>5</sup>.

- Гэрлэгсдийн хүчин гэсэн ойлголтыг агуулж байгаа эсэх
- Бие махбодын бүхийл хэсэгт нэвтрэн хавьтахыг хүчин, эсвэл бэлгийн халдлагын ямар нэг хэлбэр болгон тодорхойлсон байгаа эсэх
- Хохирогч ухаангүй, согтуу болон мансуурлын байдалд, эсвэл унтаж байсан зэрэг биеэ хамгаалах боломжгүй буюу чадваргүй байх зэрэг онцгой нөхцөл байдлыг авч үздэг эсэх
- Гадны ямар нэгэн биет, зүйлийн тусламжтайгаар нэвтэрсэн зэргийг хамарсан эсэх
- Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлэх, тулган шаардах зэрэг хүчингийн ямар хэлбэрийг тодорхойлсон эсэх
- Хүчирхийллийн болзошгүй хохирогчид эрчүүдийг хамруулсан байгаа эсэх

Тухайн Улс орон хүчиндэх гэмт хэрэгт эдгээрийн алийг нь хамруулсан, яг юу гэж тодорхойлсоноос тухайн гэмт хэргийг нотлох баримтуудад тавигдах шаардлагад нөлөөлдөг байна. Тухайлбал хүч хэрэглэсэн шинжийг шаардаж байгаа бол хэргийг шүүхэд шилжүүлэхийн тулд эсэргүүцэл үзүүлснийг илтгэх нотолгоог ихэнх тохиолдолд шаарддаг байна.

Жишээлбэл: Манайд хохирогч хүчиндүүлсэн гэж үзэх гол шинж нь гэмт этгээдийн халдлагын эсрэг тодорхой эсэргүүцэл үзүүлэх буюу хурьцал үйлдэхийг зөвшөөрөөгүй байхыг шаарддаг байна.

---

<sup>5</sup>Цагдаагийн ерөнхий газар -Хүчин ба бэлгийн халдлага гарын авалга

Манайд хүчингийн болзошгүй хохирогчид эрчүүдийг тооцдоггүй. Гэвч тэгш эрхийн зарчим, адилхан хүн гэдэг утгаар нөлөөлөх сэтгэл зүйн нөлөөлөл, хор уршгийг болон сүүлийн үед энэ төрлийн гэмт хэрэг гарах болсон, хүмүүсийн бэлгийн чиг хандлага өөрчлөгдөж буй өнөө үед цаашид бодолцох л асуудал. Австрали, Оросын холбооны улсуудад хүчиндэх гэмт хэргийн хохирогчид эрэгтэй, эмэгтэй аль альныг нь тооцдог байна.

Үүнээс үзэхэд Хууль тогтоогч Хүчин түүнтэй холбоотой гэмт хэргийг бүрэн, төгс тодорхойлоогүй, түүнтэй холбоотой гарсан УДШ-ийн 1989.-10-13-ны өдрийн 28-р тогтоолоор батлагдсан тайлбар нь одоог хүртэл утга агуулгаараа хуульчдын дунд үйлчилж байгаа нь нийгмийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал:

Нэг: Хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг буюу “хүүхэд, гэр бүл, нийгэм ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”-ийн зэрэглэлд авч үзсэн байна.

Олон улсын Эрүүгийн шүүхийн байгууллагын тухай 1998 оны Ромын дүрэмд хүчин, бэлгийн боолчлол, албадлагын биеэ үнэлэлт, албадлагын жирэмслэлт, албадлагын үр хөндөлт болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийллийг олон улсын эрх зүйд анх удаа “хүн төрөлхтөний эсрэг хийсэн гэмт хэрэг болон цэргийн гэмт хэрэг” хэмээн авч үзсэн байдаг.

Гэтэл манайд энэ асуудалд багтах хүчиндэх гэмт хэргийг зөвхөн хүүхэд, гэр бүл, нийгэм ёс суртахууны эсрэг гэмт хэргийн бүлэгт авч үзэж байгаа нь уг хэргийн хор уршиг, нийгмийн аюулыг төдийлөн үнэлэхгүй байгааг харуулж байна. Иймд хүчиндэх гэмт хэргийн нийгмийн хор аюул, охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд учруулж

буй хор уршгийг харгалзан үзэж “Хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр төрийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтэй” адилтган үзэх нь зүйтэй байна.

Хоёр: Хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг бүрэн төгс тодорхойлоогүй байна.

Энэ гэмт хэрэг нь бодит амьдралд ихэвчлэн итгэл эвдэх, хууран мэхлэх, эрх мэдэл, давуу байдлаа ашиглан эрхшээлдээ оруулах, тулган хавчих замаар үйлдэгдэж байна. Өөрөөр хэлбэл нь ихэвчлэн бага насны, өсвөр үеийн охидыг хүчиндэх, ураг төрлийн хүмүүс болон танил хүмүүсийн хооронд итгэлийг нь эвдэх, хууран мэхлэх аргаар үйлдэгддэг бөгөөд энэ тохиолд ихэвчлэн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэдгээр хэрэгсэхгүй болж байна.

2007 онд 491 хүчингийн хэрэгт мөрдөн байцаалт явуулснаас 116, 2008 онд 487 хэрэгт мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулснаас 74 хэрэг хэрэгсэхгүй болсон байна<sup>6</sup>.

Манай Эрүүгийн хуульд хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах замаар үйлдэгдсэнийг л гэмт хэрэгт тооцож байна.

Иймд Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлд “итгэл эвдэх, хууран мэхлэх” гэж нэмж оруулах шаардлагатай байна.

Гурав: Манай Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийг тодорхойлохдоо: хохирогч зөвшөөрөх, зөвшөөрөхгүй тухай ойлголт байхгүй байна. Харин УДШ-ийн тайлбар-т “хохирогч хүчиндүүлсэн

<sup>6</sup>Улсын Мөрдөн байцаах газраас авсан тоо мэдээ

гэж үзэх гол шинж нь гэмт халдлагын эсрэг тодорхой эсэргүүцэл үзүүлсэн буюу хохирогч хурьцал үйлдэхийг зөвшөөрөөгүй байх явдал” гэж тодорхойлсон байдаг.

Энэ нь хуульчдыг уг хэргийг нотлохдоо хохирогчийн зүгээс нотлох баримт шаардах, зөвшөөрсөн болон зөвшөөрөөгүйд гол анхаарлаа хандуулахад хүргэж улмаар хохирогчийг буруутгах, тэднийг нотолгооны эх сурвалж болгон ашиглах байдалд хүргэж байна.

2000 оны 3 дугаар сард МУ-ын Засгийн газраас НҮБ-ын Хүний эрхийн хороонд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаар ээлжит 4 дэх илтгэлээ хэлэлцүүлсэн билээ.

Хүний эрхийн хороо илтгэлтэй холбогдуулан гаргасан дүгнэлтэндээ Монгол Улсад гарч байгаа дэвшлийг сайшаан тэмдэглэхийн сацуу дараах асуудлыг шийдвэрлэхийг зөвлөмж болгожээ. Үүнд: Хүчиндэх хэргээр гэм буруутай этгээдийг хариуцлагад татахын тулд хохирогч хүчирхийлэлд өртсөн тухай нотлох баримт шаарддаг эрх зүйн тогтолцоо одоо хүртэл үйлчилж байгааг онцлон тэмдэглэж үр дүнтэй арга хэмжээг авахыг зөвлөсөн байна.

Гэвч одоог хүртэл энэхүү тогтолцоо хэвээр хадгалагдсаар байгаагаас олон эмэгтэйчүүд хуулийн байгууллагад хандахгүй нуугдмал далд хэлбэртэй байна.

Мөн хохирогч хүчиндүүлсэн гэж үзэх бас нэг шинж нь гэмт этгээдийн халдлагын эсрэг тодорхой эсэргүүцэл үзүүлсэн байхыг шаарддаг.



Гэвч ихэнх тохиолдолд хүчингийн гэмт хэргийн хохирогч нь айж балмагдан, цочролд орсноос эсэргүүцэх чадваргүй “хүлцэнгүй” байх, нөгөө талаас хүчирхийлэл үйлдэгч зорилгодоо хүрэхийн тулд бүгдийг урьдаас төлөвлөсөн амь насыг нь бүрэлгэхээс буцахгүй байдгаас хохирогч өөртөө амсах хор уршигийг багасгахын тулд “Эсэргүүцэл” үзүүлдэггүй байна.

Энэ нь цаг хугацаа, гэмт хэрэг үйлдсэн газар, хүчирхийлэгчээс хүний эрхийг зөрчсөнөөс давуутайгаар эмэгтэй хүн өөрөө хүчиндүүлэхээс зайлсхийж, өөрийгөө хамгаалах үүрэгтэй гэж хохирогчийг буруутгах үндэслэл болж байна. Энэ бүх байдлаас хохирогч өөрийгөө хамгаалж чадаагүй гэж буруутгагдахаас эмээж, хуулийн байгууллагад хандахгүй тохиолдол байна.

Мөн эмэгтэй хүний биеэ авч явж байсан өмнөх байдал, тухайн үед хэрхэн хувцаслаж байсан, шүүгдэгч, хохирогч хоёрын өмнө, хойшдын харьцаа зэргийг харгалзан үзэхийг Улсын дээд шүүхийн тайлбарт тусгажээ. Иймээс хохирогчийг богино юбка өмссөж өөрөө өдсөн гэх, мөн хүчирхийлэгчтэй урьд өмнө дотно харилцаатай байснаар нь буруутгах үндэслэл болж байна. Хүчирхийлэл үйлдэгчтэй урьд өмнө харилцаатай байсан нь хүчирхийлүүлсний хор уршгийг багасгах бус, харин ч улам даамжруулдаг байна

Энэ бүх нөхцөл байдлыг харгалзан үзэж, 2002 онд шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн хүрээнд нийцүүлж 1989 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Дээд Шүүхийн тайлбарыг шинэчлэн өөрчлөх шаардлагатай байна.

Ийнхүү өөрчлөхдөө хохирогчийн мэдүүлэгт хүндрэлтэй нотолгоо шаардахгүй байх, хохирогчийн урьд өмнөх бэлгийн харилцааны түүх, үйлдлийг нотлох баримтанд тооцохгүй байх шаардлагатай байна.

Мөн тайлбарт “Зөвшөөрөөгүй байдал нь заавал эсэргүүцлээр илрэх ёстой гэсэн ойлголтыг шинэчлэх, хүчиндүүлсэн гэж үзэх гол шинжид хохирогч хүсээгүй байх гэсэн утга агуулгыг” гол нөхцөл болгон оруулах нь зүйтэй байна.

Эсвэл Зөвшөөрсөн гэж тооцохгүй байх үндэслэлүүдийг маш тодорхой зааж өгөх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл зөвшөөрөл нь айлган сүрдүүлгийн дор өгөгдсөн эсвэл буруу ойлгосны улмаас өгөгдсөн бол зөвшөөрсөн гэж тооцохгүй байх гм үндэслэлүүдийг тодорхойлох шаардлагатай байна.

2002 оны эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэргийг хохирогчийн гомдлоор үүсэх хэрэгт тооцохгүй болсон явдал нь энэ хэргийн хохирогчийн эрх зүйн байдлыг сайжруулах чухал дэвшил болсон хэдий ч төрөөс Үндсэн хуулийн 16 –р бүлэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу хохирогчийн хохирлыг барагдуулах асуудал ялангуяа сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд маш тодорхой болгож, хохирлыг үнэлэх үнэлгээний аргачлал, загварыг бий болгох шаардлагатай байна.

Мөн хуулийн байгууллагууд хохирогчтой ажиллахад баримтлах ёс суртахууны зарчмуудыг тодорхойлсон, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын нууцлал, аюулгүй байдлыг хангах, байцаан шийтгэх ажиллагааг аль болох түргэн шуурхай явуулах, хохирогчийг хүндэтгэсэн таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр тусгайлсан журмыг бий болгож, олон улсын шинэлэг практикийн дагуу хүчингийн гэмт хэрэгт дагнасан эмэгтэй мөрдөн байцаагчийг ажиллуулах нь зүйтэй байна.

“ÁÐª Í ÕÈÉ ÁÍ ÈÎ ÃÑÐÎ ÈÛ Í ÑÕÄÃÕÕÈÛÄ ÑÕÄÀÈÕÄÃx ÄÛ Í  
 ÁÈÀÌ ÀÕÁÍ ÁÈÄ ÕÀÈÄÄÕ, ÕÕÕÈÛÄ ÇÀÄÄÄÄÄ- È Õª ÈÁª Ð  
 ÕÕÐÄÄÌ ÆÄÄÄÕ, ßÈÄÄÄÄÐÈÄÍ ÄÄÄÕÕÐÄÈÕÛ Í ÁÁÈÄÄÈ”  
 ÑÕÄÄÈÄÄÄ



Ö.Î äãðýë  
 Ì ÕÈÑ-èéí Í Ø ÕÑ-èéí  
 Ñî òèì èî æèí äî èò ðàì ò, ñöèèàà-:

Бие махбодь, сэтгэл санааны шийтгэл, аливаа дарамт шахалт нь хүүхдийн угаас заяасан нэр төрийг эрхэмлэн дээдлэх үндсэн эрхийг зөрчиж байгаагийн хувьд дэлхий нийтээр аливаа шийтгэлийг гэр бүл, сургууль зэрэг бүхий л орчинд бүрэн устгах санал санаачлага гараад 10-аад жил болж байна. 2006 оны 12 дугаар сард Монгол дахь Хүүхдийг Ивээх сангийн санаачлагаар Боловсролын тухай хуулинд “хүүхдийн бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурах” явдлыг хориглосон нэмэлт, өөрчлөлт орсон ч сургуулийн орчинд хүүхдийн бие махбодид халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, болон бусад хэлбэрээр хүүхдийн эрхийг зөрчих явдал гарсаар байгааг 2009 онд явуулсан судалгааны дүн<sup>1</sup> харуулж байна. Түүнчлэн “Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол” Хүүхдэд үйлчилдэг зарим байгууллагуудад (ХИС, 2005), Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг

<sup>1</sup>Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын бие махбодид халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал, ХИС, ЖАЙКА, 2009

арилгах арга зам (БСШУЯ, НҮБХС, МУБИС, 2008) судалгааны үр дүнгээр сургуулийн орчинд бие махбод, эдийн засаг, сэтгэл санааны шинжтэй хүчирхийллийн үйлдлүүд түгээмэл байна гэсэн дүгнэлтийг хийжээ. Судалгаагаар хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл түгээмэл илэрч, судалгаанд хамрагдсан бүх хүүхэд нэг болон түүнээс дээш шийтгэлээр шийтгүүлж байна. Энэ нь насанд хүрэгсдийн адил хүүхдийн эдлэх ёстой хүний үндсэн эрхүүд, түүний дотор хүний халдашгүй дархан байх, хувь хүний хувьд хүндлүүлэх эрх ноцтойгоор зөрчигдөж байгааг илтгэж байна.

#### ᠨᠣᠶ᠋ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠤ ᠴᠠᠭᠠᠨᠠᠨ

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд тохиолдож байгаа хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл, хууль бус төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал, тархалтыг тодорхойлоход судалгааны зорилго оршсон бөгөөд судалгааг нийгмийн судалгааны арга зүйн позитивист буюу тоон, интерпретив буюу чанарын судалгааны хандлагад тулгуурлан явууллаа. Судалгааны мэдээллийг асуулга, ярилцлага, зургийн аргуудыг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно. Судалгаанд Чингэлтэй, Хан-Уул, Дорнод аймгийн ЕБС-ийн 16 сургуулийн 1-11-р ангийн 916 сурагч, 120 багш, 48 эцэг эх, 16 сургуулийн удирдлагын төлөөллийг судалгаанд хамрууллаа. Тоон судалгаанд хамруулсан 4-11 дүгээр ангийн сурагчдын түүврийн зохистой хэмжээг тогтоохдоо нийт 4-11 дүгээр ангийн сурагчдыг 98 хувийн магадлалтай, 2 хувийн алдаатай байхаар тооцсон болно. Мөн эх олонлогт буюу нийт суралцагчдын 90 хувь нь ямар нэгэн шийтгэлд өртдөг гэж тооцон 916 хүүхдийг судалгаанд хамруулав.

#### ᠢ ᠶ᠋ᠠ ᠠᠠᠨ-ᠠ ᠣᠢ ᠣᠡᠢ ᠭᠠᠣᠡ ᠣᠣᠣᠡᠢ ᠤᠨᠳᠦᠶ᠋ᠠᠡᠠᠢ ᠠᠳᠠᠢ ᠠ, ᠨᠦᠣᠶ᠋ᠦ ᠨᠠᠢ ᠠᠠᠢ ᠤ ᠸ ᠡᠡᠣᠶᠦ

Хүүхдийн дийлэнх нь бие махбод, сэтгэл санааны шийтгэлд ямар нэг хэмжээгээр өртөж байна. Судалгаанд хамрагдсан 4-11 дүгээр

ангийн хүүхдийн 63 хувь нь бие махбодийн шийтгэлийн 21 төрлөөр шийтгүүлж байсан байна.

**Жишээ:** *Áàãø í àð í í ì í ì ð òí òèáí à. Áàãø þ ó ÷ áí èí í àçé áàéòàà çí àáí à. Õðø èí áàãø í àð ààéàçé, òàðèí çàèóó áàãø í àð òýòçç áàéààà. Ñàì áàð ì °ðàççéýí ý, ø èðýý ì °ðàççéýí ý. Ì àðààéàòààð áèáí èé ç°á áàéñàí ÷ áàãø í àð ì ç°á áí èáí à. Çàáí óóèæçí áóóè-èòààà òí á ç°á °á áàéàààðàé àýáýá. Õýáýá ÷ äçí áí í æ ì áàãàçé áýýä ÷èì ýýáçé í òòèáí à. Ì áí àé ýðççé ì ýí àèéí áàãø ø óóá òàðàé òàðæ äçáí ýáýá. x è áí è 60 áýò ì ýò. Õààýà ñàí áàé °ðàççéäýá. Õè-ýýè áóóññàí ÷ áàéàààà è áàéààà. Áàñ ø èðýýí èé ò°è òí òèí í, í í ì ø èáí ý, °ñàééò ýé áóò èààð °ø èäè°í°. Èðýí òáýý çàèóó ýí ýàð ýé áàãø í àð ò ýááýá. Í àñò àé áàãø í àð òàðèí ÷èì òýáýá.*

(Бүлгийн ярилцлага, ахлах ангийн эмэгтэй сурагчид, n=6)

Зураг 1. Сургуулийн орчинд хүүхэд ямар нэгэн хэлбэрээр шийтгүүлдэг гэж хариулсан хүүхэд, багшийн эзлэх хувийн жин



Бие махбодийн шийтгэлийн тохиолдол нь нас, хүйс, байршлаас хамаарч ялгаатай байна. Хөвгүүд бие махбодийн шийтгэлд охидоос илүүтэй өртдөг байхад анги ахих тусам шийтгэлийн тохиолдол өсч

байлаа. Тухайлбал судалгаанд хамрагдсан 10-11 дүгээр ангийн хүүхдүүдийн 73% нь бие махбодийн шийтгэлд өртөж байсан гэсэн бол 4-5 дугаар ангийн хүүхдүүдийн 52% нь ийн хариулсан байна.

Хөвгүүдийн хувьд ямар нэгэн зүйлээр шидүүлэх, цохиулах, гар чихээ мушгиулах, чимхүүлэх зэргээр бие махбодид нь халдах үйлдлүүд илүүтэй зонхилж байгаа бол түлхэх, чичих, ямар нэгэн зүйл өргүүлэх, анги цэвэрлүүлэх шийтгэлд охид арай илүүтэй өртөж байна.

1-3 дугаар ангийн 10 хүүхэд тутмын найм нь цохих, өшиглөх, алгадах, чих гарыг нь мушгих, хүзүүг нь базах, цүнх сандал өргөх, гараа өргөх, бусад хүүхдэд дэгээдүүлэх, зодуулах гэсэн 8 төрлийг дүрсэлжээ. Мөн тэд үймүүлсэн, муухай бичсэн, хичээлээ буруу хийсэн, хичээлийн дундуур ярьсан хүүхдийг ангид нь үлдээдэг хэмээн зурж тайлбарлажээ.

**Жишээ:** *Áàãø òè-ýýëýú ì óóàé áè-áýè àí àèà çèäýýäýä. Ì óóàé áè-áýè òàðàí òóé °ð°°í ä òèéí ý ø çç äýäýä. Ø èðýýí ýýñýú áí ñí í ä ýààðàä ø èðýýí äýýðýý í -èæñóó äýýä ò í èäí é ðóó í ýñàèñàí. Áðàãø àà òàðñàí -èí ü ø óäí ààð òí òèðí ä °ääñ°í. Áàãø èéääà òí öüñí í ò óóàé öýí í ýäýí ä ýðüääääçé, í óóò áí èí òí î ð, äýðäýýú ì àí àé áàãø ñàéí òçí.*  
(Зураг зурах арга, 6 настай, эрэгтэй сурагч)

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн хариултыг багш нарын хариулт мөн баталж байна. Судалгаанд хамрагдсан багш нарын 93% нь бие махбод, сэтгэл санааны шийтгэл хэрэглэж байсан гэсэн билээ.

Судалгаанд хамрагдсан багш нар хүүхдийг бие махбод, сэтгэл санаагаар шийтгэдэг үндсэн шалтгаан нь хүүхэд үймүүлэх, гэрийн даалгавраа хийгээгүй зэрэг сургалт хүмүүжлийн асуудалтай холбогдож байна.

Өөрөөр хэлбэл шийтгэлийг сургуулийн орчинд сахилга батыг тогтоох арга болгон хэрэглэж байгааг харуулж байна. Харин судалгаанд хамрагдсан нийт багш нарын 86 хувь нь хүүхдийг бие махбодийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамтгүйгээр хэрхэн хүмүүжүүлэхийг мэддэг гэж хариулсан ч тэдний ихэнх нь судалгаанд хамрагдсан сургуулийн удирдлага, эцэг эхийн адилаар хүүхдийг шийтгэхийг зөвтгөсөн байр суурь баримталдаг болох нь харагдсан. Мөн хүүхдүүд ч бид үймүүлж, сахилгагүйтсэн тул шийтгүүлэх нь зөв хэмээн судалгаанд хамрагдсан 4-11 дүгээр ангийн хүүхдүүдийн 50 хувь нь дэмжсэн байна.

Анхаарал татсан нэг зүйл бол судалгаанд хамрагдсан 16 сургуулийн багш нарын 88% нь Боловсролын тухай хуульд суралцагчын бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглосон нэмэлт өөрчлөлт орсон тухай мэдэхгүй байлаа.

#### Ө , ө. Өööüä çààäääé é ө өá° ө, өóääàì æ

Боловсролын тухай хуулинд ЕБС-д суралцагчаас хуулинд заагаагүй төлбөр хураамж авахыг хориглосон ч Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдээс хууль бус төлбөр хураамж авах явдал түгээмэл байгааг судалгааны баримт харуулж байна. Судалгаанд хамрагдсан хүүхэд, багш нарын 80-аас илүү хувь нь аливаа төлбөр, хураамж өгдөг, авдаг гэсэн нь анхаарал татсан асуудал байсаар байгааг илтгэж байна.

Хүснэгт 1. Суралцагчаас татдаг мөнгө, хураамжийн төрлүүд, судалгаанд хамрагдсан респондентуудаар

1-3-᠔ ай өдөр нөдөл:еэ (n=80)	4-11-᠔ ай өдөр нөдөл:еэ (n=916)	Ааар (n=120)
Ном	Анги цэвэрлэгээний материал	Анги цэвэрлэгээний материал
Анги цэвэрлэгээний материал	Ангийн хуримтлал, фонт	Ангийн хуримтлал, фонт
Ангийн хуримтлал, фонт	Ангийн засвар	Ангийн засвар
Ангийн засвар	Сонин захиалга	Сонин захиалга
Сонин захиалга	Гарын саван, ариун цэврийн цаас	Үзвэр үзүүлэх
Гарын саван, ариун цэврийн цаас	Үзвэр үзүүлэх	Сургуульд хандив өргүүлэх
Үзвэр	Ангид эд зүйл авах /хошиг, хулдаас, буцалгагч г.м авах	Гарын авлага, шалгалтын тест, сургалтын материал худалдан авахуулах, зарах, канондуулах
Ангид эд зүйл авах /хошиг, хулдаас, ус буцалгагч г.м авах	Үдийн цай, форм	Сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэх
	Хандив, сургуульд хандив өргүүлэх Шинэ жилийн бэлэг, чимэглэл	Сургуулийн ой, багш нарын алдар тэмдэглэх Төгсөлт, хонхны, цагаан толгойн болон бусад баяр
	Сурах бичгээс бусад ном хэвлэл зарах Гарын авлага, шалгалтын тест, сургалтын материал худалдан авахуулах, зарах, канондуулах Шивүүлэх даалгавар өгөх	Олимпиад уралдаан зохион байгуулах Кабинет, анги тохижилтод зориулж эд зүйлс авчруулах
	Сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэх Сургуулийн ой, багш нарын алдрыг тэмдэглэх	Гачигдал, эмчилгээ, төлийн бэлтгэл Багшийн цалин хөлсөөс суутгах /сурагч нь тасалсан, хожимдсон гэж
	Төгсөлт, хонхны, цагаан толгойн болон бусад баяр Төлбөртэй давтлага	Сургуулийн удирдлага, захирлын тушаалаар
	Англи хэлний сонгон, бие даалт Олимпиад уралдаан зохион байгуулах Кабинет, анги тохижилтод зориулж эд зүйлс авчруулах, мөнгө авах	
	Хичээл таслах, хожимдоход Цаас хаясан, бохьажилсан гэж торгуулах Гачигдал, эмчилгээ, төлийн бэлтгэл	
	Багшийн цалин хөлсөөс суутгах /хожимдсон, тасалсан Сургуулийн заал, эд зүйл хэрэглэсний түрээс авах	
	Сургуулийн удирдлага, захирлын тушаалаар	



Бага ангийн сурагчдын дийлэнх нь, 4-11-р ангийн сурагчдын 94 хувь нь, багш нарын 90 хувь нь хүүхдээс мөнгө татах, эд зүйлс авах зэргээр хуульд заагаагүй төлбөр хураамж авдаг болохыг хүлээн зөвшөөрч байна. Судалгааны дүнгээс харахад сургуулийн анги засвар, ангийн хуримтлал үүсгэх, анги цэвэрлэгээний материал авах, төрөл бүрийн ойн арга хэмжээг тэмдэглэхэд хүүхдүүдээс мөнгө татах үзэгдэл түгээмэл байгаа бол шивүүлэх, канондуулах даалгавар өгөх, анги танхимийг тохижуулахад шаардлагатай эд зүйлсийг сурагчдаас гаргуулах тэр ч бүү хэл сурч байгаа сургуулийнхаа заал танхимд тоглохын тулд мөнгө төлөх, хүүхдүүд хичээлээс хоцроход багшийн цалингаас хасдаг дотоод журамтай тул багш хоцорч ирсэн хүүхдүүдээс мөнгө авахад хүрч байгаа тохиолдол цөөн бус байгааг судалгааны баримт харуулж байна.

Сургуулийн удирдлага, багш нарын үзэж байгаагаар сургуулийн төсөвт анги танхим засварлах, тохижуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, болон соёл хүмүүжлийн үйл ажиллагаанд мөнгө хуваарилдаггүй учраас хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд мөнгө татдаг гэж үзэж байна. Тухайлбал нийт судалгаанд хамрагдсан багш нарын 81 хувь нь багшид сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад нь сургуулиас ямар нэгэн дэмжлэг туслалцаа болон хөрөнгө санхүүжилт гаргадаггүй гэж хариулснаас ингэж үзэж болохоор байна.

ЕБС-ийн сургуулиудад төлбөр хураамжтай холбоотой асуудлаар шүүмжлэл нэлээд гарч байгаа учраас анги удирдсан багш болон багш нарыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан асуудлыг шийдэж байхыг боловсролын байгууллага, сургуулийн удирдлагын зүгээс үүрэг даалгавар болгосны дагуу эцэг эхийн зөвлөлтэй хэлэлцэж асуудлыг шийддэг болжээ. Эцэг эхчүүд ч хүүхдээс төрөл бүрийн төлбөр хураамж авдаг гэсэн бөгөөд хүүхдэд нь сөргөөр нөлөөлөхөөс эмээж ихэнх тохиолдолд шаардсан мөнгө, төлбөр хураамжийг өгдөг



Багш сургалтын процессод идэвхгүй оролцдог сурагчдад анхаарал тавихгүй орхих, үл хайхрах явдал цөөн бус гардаг болох нь тоон болон чанарын судалгаанаас харагдсан бөгөөд ялангуяа бүлгийн хэлэлцүүлэгт хамрагдсан хүүхдүүд багш тааруу суралцдаг, тааруу амьдралтай хүүхэдтэй төдийлөн харьцаад байдаггүй, тоодоггүй хэмээн үзсэн юм. Гэтэл хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийг үл хайрхах асуудал онцгой байр суурь эзэлдэг байхад хүүхдийг эрхийг хангаж хамгаалах үүрэгтэй институци болох сургуулийн орчинд хүүхдийг үл хайрхах үзэгдэл байсаар байгааг судалгаа харуулж байна. Мөн сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаар ч багш сурлага сайтай, боломжтой айлын хүүхдэд илүү анхаарал тавьж, илүү ажилладаг хэмээн үзсэн нь сургуулийн орчинд хүүхдэд ялгаатай хандах тохиолдол гардгийг хүлээн зөвшөөрч байлаа.

**Ä° ð° ä. Nódãóóèèéí î ð÷èí ä ýðõ í ü ç° ð÷èääñ° í õ¿¿õä¿¿äýä öýðýäýé äýì æèýä**

Судалгаанд хамрагдсан 1-3 дугаар ангийн хүүхдүүдийн олонхи нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртсөн тохиолдолд хэн нэгэнд ханддаггүй гэсэн байна. Хүүхдүүдийн хувьд дахин шийтгэл, дарамтад өртөж болзошгүй гэсэн айдас түгшүүр нь хэн нэгэнд хандахгүй байх шалтгаан нь болж байна. Харин сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн үед хамгийн түрүүн хүүхдийг хамгаалах үүрэгтэй сургуулийн нийгмийн ажилтанд сурагчдын ердөө 1.1 хувь нь хандаж байна. Хүүхдүүд сургуулийн нийгмийн ажилтны үүргийн талаар тодорхой мэдээлэлгүй, мөн нийгмийн ажилтан эрхэд суурилсан хандлагаар хүүхэдтэй ажиллах нийгмийн ажлын арга зүй, практикаа дээшлүүлэх шаардлагатай болох нь судалгаанаас ажиглагдаж байлаа.

Сургуулийн орчинд эрх нь зөрчигдсөн үед хүүхдийн хамгийн их хүсэн хүлээдэг зүйл нь багш нар болон насанд хүрэгчидтэй нээлттэй

ярж ойлголцох явдал гэж үзсэн төдийгүй хүүхдийн эрхийг зөрчих явдлыг бууруулах арга зам хэмээн хүүхдүүд үзлээ. Судалгаанд оролцсон 4-11 дүгээр ангийн хүүхдийн 13 хувь нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтанд өртсөн тохиолдолд сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх хэрэгтэй гэсэн байна.

**ᠨᠣᠶᠢᠨᠦᠨᠢᠨᠦᠨᠢᠨ ᠨᠥᠡᠭᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠵᠡᠡ ᠶᠠᠭᠠ, ᠢ ᠠᠢ ᠠᠶᠢ ᠠᠢ ᠣᠶᠢ**  
**ᠦᠵᠡᠵᠡᠶᠡᠶᠡᠶᠡ ᠢ ᠳᠢ ᠡᠦᠢ ᠦᠶᠢ**

Суралцагчидтай холбоотой аливаа асуудлаар сургуулийн шийдвэр гаргах үйл явцад судалгаанд хамрагдсан хүүхдийн 50 хувь нь л оролцдог гэжээ. Сурлагаар тааруу, сонгуульт ажил хийдэггүй хүүхдүүд шийдвэр гаргах үйл явцаас гадуур үлддэг гэж хүүхдүүд үзсэн юм. Сургуулийн шийдвэр гаргах үйл явц, удирдлагын үйл ажиллагаанд эцэг эх зэрэг оролцогч талуудыг хязгаарлагдмал оролцуулдаг практикаас харвал сургуулийн удирдлага, менежментийн тогтолцоо ил тод бус байгааг судалгаа харуулж байна.

**ᠨᠣᠶᠢᠨᠦᠨᠢᠨᠦᠨᠢ ᠤ ᠴᠦ ᠠᠡᠦᠦ ᠢ ᠡ**

1. Сургуулийн орчинд бие махбод, сэтгэл санааны шийтгэл, ялгаварлан гадуурхалтыг зогсоох талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах, буюу олон улсын болон үндэсний холбогдох хууль тогтоомжын зохицуулалт, тэр дундаа Монгол улсын Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээллийг түгээх ажлуудыг өрнүүлэх

2. Багш нарын хүүхэдтэй ажиллах сургалт, хүмүүжлийн эерэг арга, түүнийг практикт хэрэглэх талаар чадавхийг сайжруулах, багш хүүхдийн хоорондын эерэг харилцааг хөгжүүлэх

3. УИХ, Засгийн газар болон холбогдох дээд шатны байгууллага, эрх мэдэл бүхий албан тушаалтнууд хууль бус төлбөр хураамжийн асуудлыг гүйцэт шийдвэрлэх асуудлаар нөлөөллийн ажил явуулах. Үүнд:

- Сургуульд хүрэлцэхүйц төсөв мөнгө хуваарилах,

- Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон харъяа салбар институт, эрх мэдэл бүхий субъектүүдээс батлан гаргаж байгаа тушаал, шийдвэр зэрэг хэм хэмжээний актуудын хоорондын зөрчлийг арилгах,

- Багш нарт хариуцлага хүлээлгэх одоогийн тогтолцоог эргэн харах, сайжруулах

4. Сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах эрхзүйн орчинг бэхжүүлэх, ингэхдээ эрх нь зөрчигдсэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журам, тогтолцоог бий болгох, хүүхдийн эрхийг зөрчсөн хүнд арга хэмжээ авах

5. Сургуулийн Зөвлөлийн эрх, үүргийг эрх зүйн бичиг баримтанд тодорхой заалтаар оруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, сургуулийн дотоод журамд сургуулийг илүү нээлттэй, ил тод, тэгш оролцоог хангасан болгоход менежментийг зөвлөл нөлөө үзүүлэхүйцээр зааж өгөх

6. Шийдвэр гаргах үйл явц, төлөвлөлт, менежментэд эцэг эхийг идэвхтэй, сайн оролцуулахыг сургуулиудад ухуулан таниулах.

#### Аө èäãàñàí ì àcàðèèèù í æãñàèèò

1. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын бие махбодид халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал, ХИС, ЖАЙКА, 2009

2. БСШУЯ, НҮБХС, МУБИС, ХЭҮК (2007) Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам. Судалгааны тайлан

3. ХИС, ЗХЖТ (2005) Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол”Хүүхдэд үйлчилдэг зарим байгууллагуудад

4. Ts.Odgerel ‘Corporal Punishment of Children: Views of Children in Some Schools, Kindergartens and Institutions’ Sociology: Journal (UB, NUM) Vol 7. 2007

5. Save the children (2005) Зүүн Өмнөд Ази болон Монгол дахь Хүүхдийн бие махбод сэтгэл санал санааны шийтгэл. Нэгдсэн тайлан



ᠨᠠᠶᠢᠨᠠ

ᠨᠢᠶᠴᠠᠨ-ᠡᠡᠶᠢ ᠶᠡᠨᠡᠨᠢ

Цаана чинь хүний эрхийн тухай асуудал бүрэн шийдэгдээгүй, түүнийг хамгаалж ч чадаагүй байхад энд оюутны эрхийн тухай асуудлыг хөндөх ямар ч шаардлагагүй, чухал бус зүйл хэмээгчид бий. Энэ талаар хүмүүс янз бүрийн бодолтой байдаг бөгөөд олон ургальч үзэл бүхий иргэний ардчилсан нийгэмд байж болох л зүйл. Янз бүрийг сэтгэх эрх чөлөө бол ардчилалын үнэт зарчим. “Аль ч засаглалын ялзрал нь ямагт зарчим нь завхрахаас эхэлмэй”<sup>1</sup> хэмээх Монтеスキо эрхмийн үгийг эш болговол аливаа нэг эрхийн зарчмыг эвдэх нь бусад эрхийн зарчмыг эвдэх үндэс суурьтай агаар нэгэн ажгуу.

Хүнд хүний эрх, иргэнд иргэний эрх чухал зарчим байдаг бол оюутанд оюутны эрх гол зарчим ажээ. Эдгээр эрхийн алдаж буй нөхцөл байдал нь ерөөс ижилхэн бөгөөд хамгийн энгийн эрхээ ч эдэлж чадахгүй аваас бусад эрхүүд мөн тийм замаар алдагдах ажээ. Оюутны эрхийн тухай асуудлыг чухалчлан үзэх хэд хэдэн нөхцөл бий. Үүний тулд оюутан, түүний эрх, хамгаалж буй тогтолцоо, оюутны өөрсдийн бий болгосон сайн дурын нэгдэл, нийгмийн оролцооны тухай цогцоор нь сонирхон авч үзэх шаардлагатай.

<sup>1</sup>‘Хуулийн амин сүнс’ номны VIII дэвтэр, I бүлэг.

### Í þ óðáí

Нийгмийн оюун санааны хамгийн чухал хэсгийн нэг бол оюутнууд байдаг. Хамгийн хөдөлгөөнтэй хувьсах оюун санааны ертөнц энд үүсэх бөгөөд ихэнхи залуу хүмүүс энэ л цаг хугацаандаа ертөнцийг үзэх үзлээ олж авдаг. Өнөөгийн оюутнууд нь маргааш нийгмийн үзэл санааг тодорхойлогч, чиглүүлэгч, удирдан авч явах гол хүмүүс болдог. Тиймээс тэдний сэтгэлгээ хэдий чинээ өндөр, хүний эрх, эрх чөлөө, ардчилалын үнэт зүйлсийг өөрсөддөө нэвт шингээсэн байх тусам төдий чинээ манай нийгмийн ирээдүй улам бүр баталгаатай, эрх чөлөөтэй, хүний эрх хамгаалагдсан байх нэгэн үндэслэл болох ажээ. Тиймээс өнөөдөр оюутны эрхийн төлөө тууштай зогсож байгаа идэвхитэн оюутнууд ирээдүйд ардчилал, хүний эрхийн төлөө мятрашгүй тэмцэгчид болох юм. Оюутан насны амьдрал нь нийгэмд гарахын өмнөх томоохон бэлтгэл байдаг бөгөөд оюутан байх хугацаандаа оюутны эрхийг ухамсарлаж, түүнийхээ төлөө тэмцэж чадаж байгаа нь угтаа хүний эрх, эрх чөлөө, либерал үзэл, ардчилал зэрэг үнэт зүйлсийг ухамсарлаж, түүнийг улам бүр цааш дэлгэрүүлэн судлах үндэс болдог байна. Ингэснээр манай улсын ирээдүйн боловсон хүчин болсон оюутнууд эрх чөлөөний байнгын манаачид болсноор улс оронд дарангуйлал тогтох, бурангуй тогтолцоо үүсэх, хэт их эрх мэдэлтэй данхайсан төр бий болох магадлалыг эртнээс багасгаж байх ач холбогдолтой юм.

### Í þ óðí ù ýðð

Оюутны эрхийн уг гарвалыг хөөн үзвэл Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхтэй, улмаар Хүний эрхийн түгээмэл тунхаглалтай салшгүй холбоотой байдаг. Оюутны эрхийг тусгасан хуулийн хувьд Боловсролын хуулийн 45-р зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 16-р зүйл ордог хэдий ч илүү өргөн хүрээтэй, өмнө дурьдсан хуулийн заалтуудыг өөртөө бүрэн агуулж чадсан баримт бичиг нь Монголын Оюутны эрхийн түгээмэл тунхаглал юм.





чадах билээ. Тийм ч учраас оюутнууд өөрсдийн эрхийн талаар мэдлэггүй тохиолдолд тэрхүү хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх нь цаасан дээр буусан хэдэн мөрөөс ялгамгүй болдог. Манай улсын хувьд дээрх замаар оюутны эрх хамгаалагдахгүй, бүр сураггүй алга болдог байна. Оюутнууд эрхээ мэддэггүй, түүнчлэн сургуулийн захиргаа, оюутны зөвлөл холбоод нь энэ талаар оюутнууддаа хангалттай боловсрол олгож чаддаггүй. Эндээс хэд хэдэн бэрхшээл гарч ирдэг.

Сургуулийн захиргаанаас оюутнуудын эрх, үүргийн талаар тодорхой мэдээлэл дутуу дулимаг хийдэг нь зарим талаар оюутнуудыг эмх журманд нь байлгах гэсэн хүсэл, тодорхой бус байдлаар дөрөөлөн давуу тал олох оролдлого байж болох юм. Нэн ялангуяа тодорхой бус ёс зүйн бичигдээгүй хэм хэмжээг ашиглаж эхлэх нь асуудлыг үнэхээр ээдрээтэй болгодог аж. Эртний Ромд патрицууд шүүн таслах эрхтэй байсан ба дан гагц уламжлал, эсхүл тодорхойгүй аман хуулиар аливаа харилцааг зохицуулдаг байв. Энэ нь хуулийг батлан гаргасан патрицууд хуулийг өөрсдөдөө ашигтайгаар эргүүлж шударга бус явдлыг гааруулах болсон бөгөөд улмаар нийгэм эмх замбараагүй болжээ. Харин МЭӨ 449 онд “Арван хоёр самбарын хууль”<sup>3</sup> хэмээх анхны бичигдмэл хуулийг зохиож Ром хотын олон нийтийн төв газар Форумд байрлуулснаар, аливаа тодорхойгүй асуудлыг эцэслэн шийдвэрлэж нийгэмд эмх журмыг тогтоож чадсан. Манай их, дээд сургуулийн хувьд оюутантай холбоотой эрх үүргийн харилцаа бүрхэг байгаа нь сургуулийн захиргаа эртний Ромын патрицууд адил оюутны эрхийг хүчирхийлэх гол арга хэрэгсэл болчихоод байна. Өнөөдөр манай улсын хувьд оюутан, багш нарын ёс зүйн тухай ямарваа нэг хүчин төгөлдөр заалт байхгүй, харин БСШУЯ-аас гаргасан Их сургууль, дээд сургууль,

<sup>3</sup> [http://en.wikipedia.org/wiki/Twelve\\_Tables](http://en.wikipedia.org/wiki/Twelve_Tables)

коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм гэх төсөл төдий зүйл л байна<sup>4</sup>. Ихэнхи их, дээд сургуулийн дүрмэнд оюутан болон сургуулийн захиргааны хоорондын эрх зүйн харилцааг дэлгэрэнгүй тусгасан баримт бичиг байхгүй байна.

Их, дээд сургуулийн захиргаанаас ийм төрлийн баримт бичиг байгаа гэж хэлж магадгүй юм. Гэтэл энэ баримт бичиг нь оюутнуудад ил тод нээлттэй бус учир байхгүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Хэрвээ үнэхээр байгаа юм бол сургууль гол самбар дээрээ дүрэм журмаа ил тод нийтлэн гаргах нь тодорхойгүй байдлыг эцэслэн шийдвэрлэж, дүрэм журам жинхэнэ утгаараа оршин байх гол үндэс юм. Харин тэрхүү дүрэм журмын мөн чанарын тухайд хэдэн зүйл өгүүлье.

Оюутантай холбоотой дүрэм журам нь Үндсэн хууль, боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудтай нийцсэн байх нь зайлшгүй ба сургуулийн захиргаа оюутантайгаа зөвшилцөлгүйгээр, оюутны эрх үүрэгтэй холбоотой дүрмийг ямар ч тохиолдолд гаргаж болохгүй. Сургуулийн захиргаа болон оюутны хооронд бий болох харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг хоёр тал зөвшөөрсний үндсэн дээр батлах нь зүй ёсны хэрэг.

Эсрэг тохиолдолд сургуулийн захиргаа дан гагц өөрөө мэдэн батлах аваас, энэ нь оюутнаа үл хүндэтгэсэн тулган шаардалт болох юм. Оюутанд юу хэрэгтэй, амин чухал байгааг сургуулийн захиргаа, багш нараас илүүтэйгээр оюутнууд өөрсдөө мэддэг, тийм ч учраас сонголтоо хийж санал шүүмж тавин хэлэлцдэг. Төр эдийн засагт хэт их оролцоод ирэхээр тааламжгүй үр дүнд хүрдэгтэй адил,

<sup>4</sup> [http://mecs.pmis.gov.mn/index.php?option=com\\_content&task=view&id=316&Itemid=2](http://mecs.pmis.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=316&Itemid=2)

оюутны хувийн эрх чөлөөнд сургуулийн захиргаа хутгалдаад байх нь таагүй нөхцлийг бүрдүүлнэ.

Нөгөө талаас оюутны өөрөө удирдах байгууллага, оюутны холбоо, зөвлөлүүд манай улс оронд хангалттай хөгжиж байр сууриа олж чадаагүй байна. Монголын оюутны холбооны тухайд 2001 оны 5-р сараас үйл ажиллагаа нь одоогийн түвшиндээ орох алхмаа хийсэн зэргийг үзвэл арав хүрэхгүй жил үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн томоохон их, дээд сургуулиудын Оюутны холбоо, байгууллагуудын эрх зүйн орчин сул дорой, тодорхойгүй байгаа нь цаашдаа энэ төрлийн байгууллагуудын үндсэн чиг үүрэг болох оюутны эрхийн асуудлаар тодорхой үйл ажиллагаа явуулахад саад тотгор учруулах үндэс болж байна. ШУТИС, МУИС зэрэг манай урдаа барьдаг их сургуулиудын Оюутны байгууллагын дүрэм нь эрх мэдлийг хуваарилах, хянан-тэнцвэржүүлэх<sup>5</sup> зарчмыг агуулж чадаагүй. Улмаар оюутны байгууллагуудын явуулж буй үйл ажиллагаа нь спорт, урлаг, зугаа цэнгэлийн шинжийг илүүтэйгээр агуулж байгаа бөгөөд эрх зүйн боловсрол олгох, оюутны эрх, эрх чөлөөний талаар явуулж буй үйл ажиллагаа нь дутмаг, хангалттай бус байдаг байна.

“Ямар иргэд байна тийм төр оршино” гэдэг шиг ямар оюутнууд байна тийм л оюутны холбоо оршдог аж. Оюутны байгууллагыг эргээд хянах субъект нь оюутнууд бөгөөд тэдний нийгмийн идэвхи оролцоо нь оюутны байгууллагад ямар хүмүүс сонгогдож ажиллахыг шийддэг. Гэтэл оюутнуудын нийгмийн оролцооны түвшин доогуур байгаа нь цөөн хэдэн оюутан нийлсэн бүлгэм нийт оюутны нэрийн өмнөөс шийдвэр гаргах, улмаар зүй бус үйлдлүүд гарах үндэслэл

<sup>5</sup> Separation of powers, check and balance гэдэг нь 18-р зууны Европын хуульч Монтёскё, Локк нараас гаралтай бөгөөд засаглалын гурван эрх мэдлийг хооронд нь салгаж, улмаар нэг нэгнийгээ хянасан аль нэг нь илүү хүчтэй болохоос сэргийлж байдаг тогтолцоо юм.

болдог байна. Өнгөрөгч хугацаанд ХААИС-ын оюутны холбооныхон захирал руугаа дайрсан, МУИС-ын Оюутны холбооны Нарийн бичгийн дарга нь нийтийн тээврийн хөнгөлөлтийн марк авч зугатсан, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Оюутны холбооны нэр бүхий албан тушаалтан мөнгө шамшигдуулсан гэх мэт хэргүүд гарсаар байгаа нь эргээд Оюутны байгууллагаа хянах оюутны нийгмийн оролцоо үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Оюутан, түүнийг төлөөлсөн оюутны байгууллага, сургуулийн захиргааны хооронд үүсэх эрх зүйн харилцааг тодорхой болгож улмаар энэ гурван талын үйл ажиллагааг зөв чиг үүрэгт (нийгмийн оролцоо өндөртэй оюутан, зөв эрх зүйн тогтолцоотой оюутны байгууллага, ил тод, нээлттэй сургуулийн захиргаа) оруулах нь оюутны эрхийг хамгаалах гол дотоод хүчин зүйл болж өгөх юм.

### ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ, ᠨᠠᠡᠯᠡ ᠠᠳᠣᠲᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ

Оюутнууд нийгмийн үйл хэрэгт оролцсоноороо нийгмийг тэр чигт нь өөрчилж чадах хүч болж чаддаг ажээ. Ардчилал, хүний эрхийн төлөө дэлхийн өнцөг булан бүрт оюутнууд тэмцэж байсан, өнөөдөр ч зарим газар тэмцсээр л<sup>6</sup> байна. Оюутны хөдөлгөөн дарангуйлагчид, цэргийн эрхтнүүдийг буулган авч<sup>7</sup>, дайныг хүртэл

<sup>6</sup> Грекийн нийслэл Афин хотод 2006 онд

<sup>7</sup> Грекийн 1967-1974 онд дарангуйлсан цэргийн засаглалыг эсэргүүцэн 1973 оны 11-р сарын 14-нд Афин хотын Политехникийн сургуулийн оюутнууд хөдөлгөөн үүсгэжээ. Тэд сургууль дотроо радио станц бэлтгэж Афин хот даяар "Политехникийн сургуулиас ярьж байна! Грекийн иргэдээ, Политехникийн сургуулийн байранд дарангуйлалын эсрэг, ардчилал эрх чөлөөний төлөөх бидний, таны, бүх нийтийн хүний тэмцэл өрнөж байна!" хэмээн цацаж байлаа. Улмаар 11-р сарын 17-нд танк оруулж ирсэн нь хөдөлгөөнийг улам гааруулж байсан ч оюутнууд эгэл цэргүүдийг зэвсэгт ахан дүүс хэмээн зарлаж цэргийн дарангуйлагч нарын тушаалыг биелүүлэхгүй байхыг уриалав. Эцсийн бүлэгт энэхүү хөдөлгөөн Грекийн цэргийн засаглалыг буулган авч улмаар 1974 онд ардчилсан сонгууль явагдсан юм. ([http://en.wikipedia.org/wiki/Greek\\_military\\_junta\\_of\\_1967-1974](http://en.wikipedia.org/wiki/Greek_military_junta_of_1967-1974)) түүвэрлэн орчуулав.

дуусгаж байсан<sup>8</sup>. Оюутнууд хүнд бэрх цагт иргэддээ улс орныг нь үндэслэн байгуулсан эцгүүд чухам юуг үнэт зүйлс болгож байсан тухай сануулж, ардчилал, зүй ёс, тэгш эрхийн зарчмыг тунхаглаж байлаа. Гэтэл өнөөдөр манай улс оронд оюутнууд нийт нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэх нь битгий хэл өөрсдийнхөө эрх, эрх чөлөөг хамгаалахад ч идэвхитэй оролцож чадахгүй байгаа нь харамсмаар. Гэхдээ энэ цаг хугацаанд хэсэг бүлэг оюутнууд нэгдэн нийлэх бололцоо олдож, түүнчлэн өөрийн үгийг илэрхийлэх боломж олдож байгаа нь бидэнд гэрэлт ирээдүй байгааг харуулж байна. Сүүлийн үед оюутны сайн дурын бүлгэм, клубууд багагүй үүсч байгаа нь оюутнуудын дунд оюутны эрх, эрх чөлөөний талаар нэгэн шинэ үе эргэн ирж байгаа юм болов уу хэмээн сэтгэхэд хүргэнэ.

Их, дээд сургуулийн захиргаа оюутнуудыг “эрх чөлөөтэй байлгаснаар тэд сайн дураараа авирлаж, эмх замбараагүй байдал үүсгэнэ” гэж болгоомжлох бус харин ч тэд эрх чөлөөт байдлыг ашиглан сайн дураараа нэгдэж, улмаар бусдын эрхийг хүндэтгэдэг, өндөр сэтгэлгээтэй бие хүн болон төлөвших үндэслэлтэй гэж үзвэл зохино. Энэхүү сайн дурын нэгдэл бүлгэмийг дэмжиж, урамшуулдаггүй юмаа гэхэд ядаж хориглож үйл ажиллагаанд нь хэт хутгалдалгүй *laissez-faire*<sup>9</sup> зарчмыг баримтлахыг сургуулийн захиргаа, төр засгаас хичээнгүйлэн хүсье.

<sup>8</sup> Америкийн нэгдсэн улсад Оюутнуудын хөдөлгөөн өрнөсөн нь Вьетнамын дайныг дуусгахад чухал нөлөө үзүүлжээ.

<sup>9</sup> ‘Зүгээр орхи’ гэсэн Франц үг. Эдийн засагт төрийн оролцоог багасгаж, үл хутгалдах явдлыг дэмжсэн чөлөөт эдийн засагчид энэхүү нэр томъёог ашигласан гэж үздэг.

ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ



ᠨᠢᠨᠡᠨᠢ

ᠨᠢᠨᠡᠨᠢ-ᠨᠢᠨᠡᠨᠢ, ᠨᠢᠨᠡᠨᠢ ᠨᠢᠨᠡᠨᠢ

Нэгдсэн Үндэсний Байгууллага болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас гаргаж буй хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээ, конвенци, зөвлөмжүүд нь улс орнуудын хөдөлмөрийн хууль тогтоомжуудыг боловсронгуй болгоход чиглэгдэж ирсэн билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хөдөлмөрлөх эрхийг - хүний үндсэн эрх мөн” гэж заасан. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23-р зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7-р зүйлд хүний хөдөлмөрлөхтэй холбоотой салшгүй эрхүүд болох хөдөлмөрлөх эрх; ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох; ажилгүйдлээс хамгаалуулах эрх; хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах; цалин хөлсийг шударгаар, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох; хүн бүр нийгмийн халамжийг хүртэх; ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх; ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох; эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд нэгдэх; ажил хаях эрхтэй; хүүхэдтэй эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр хамгааллын нөхцөлийг онцгойлон авч үзэх хэмээн тодорхойлсон байна.

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенци, Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенцүүдэд ажилчид ажил олгогчийн урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр эрхээ хамгаалах байгууллага байгуулах, энэхүү байгууллагаараа дамжуулан ажил олгогчтой хамтын гэрээ байгуулах зэрэг эрхүүдийг заасан билээ.

Харамсалтай нь хөгжиж буй улс орнуудын улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, боловсронгуй бус эрх зүйн орчин, өнөөгийн эдийн засгийн хямрал зэрэг нөхцөлүүд нь ажил олгогч ажилтны эрхийг зөрчихөд хүргэж байна. Ажилчин хүний эрхийг хамгаалах гол арга нь ажил олгогчтой хамтын гэрээ байгуулах явдал юм. МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.4-т “Хамтын гэрээ” гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог хэлнэ хэмээн томъёолоод, 3.1.7-д “ажилтны төлөөлөгчид” гэж ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үүрэг хүлээсэн үйлдвэрчний эвлэл, хэрэв ийм байгууллага байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон төлөөлөгчдийг ойлгоно гэжээ. Манай орны тухайд үйлдвэрчний эвлэлтэй байгууллагууд нь ажил олгогчтой хамтын гэрээ байгуулж, харин нийт ажилтны хурлаас сонгогдсон төлөөлөгчид ийм гэрээ байгуулсан нь байхгүй байна. Монгол Улсын хэмжээнд салбарын 13 үйлдвэрчний эвлэлийн холбоод идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр холбоодын гишүүн байгууллагууд нь 2007 оны байдлаар 642 хамтын гэрээ байгуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

ᠨᠠᠡᠠᠳᠦ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ ᠶᠡᠶᠡᠳᠦᠨ

№	Холбооны нэр	2001 ᠶᠡᠳᠦ		2002 ᠶᠡᠳᠦ		2003 ᠶᠡᠳᠦ		2004 ᠶᠡᠳᠦ		10/1/2006		2007 ᠶᠡᠳᠦ		Нийт
		ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	ҮЭ-ийн хороо	Хамтын гэрээ	
1	Ажилтан албан хаагчдын ҮЭХ	58	44	49	42	48	45	47	44	48	44	48	44	561
2	Авто замчдын ҮЭХ	27	27	27	27	27	27	27	27	23	23	23	22	307
3	Барилгачдын ҮЭХ	30	21	30	22	30	25	30	26	30	24	30	25	323
4	Боловсрол шинжлэх ухааны ҮЭХ	300	300	282	282	283	283	256	256	263	263	282	280	3330
5	Нэгдмэл ҮЭХ	42	42	42	42	28	28	28	28	24	15	19	17	355
6	Тээвэр, холбоо, газрын тосны ҮЭХ	38	28	41	33	40	38	32	32	34	31	34	28	409
7	Төмөр замчдын ҮЭХ	61	61	62	62	63	63	64	64	65	64	64	64	757
8	Мэргэжил үйлдвэрлэлийн ҮЭХ	35	35	36	34	38	38	32	32	34	34	30	30	408
9	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны ҮЭХ	25	25	25	25	25	25	23	23	25	17	21	17	276
10	Хувийн хэвшил ҮЭХ	18	17	18	18	16	16	19	19	20	20	20	19	220
11	Эрүүл мэндийн ҮЭХ	42	42	34	34	33	33	32	32	33	33	31	31	410
12	Эрчим хүч, геологи, уул уурхайн ажилчдын ҮЭХ	23	23	27	27	29	29	29	29	28	28	29	29	330
13	Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ҮЭХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	36	36	72
14	Нийт	699	665	673	648	660	650	619	612	627	596	667	642	7758

МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1-д хамтын гэрээнд хуулиар шууд зохицуулагдаагүй дараахь харилцааг зохицуулахаар заасан. Үүнд:

- үндсэн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх, түүний хэлбэр, олгох хугацаа, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох, өөрчлөх. Ажилтанд олгох хоол, унааны зардал болон бусад нөхөх олговрын хэмжээг тогтоох;
- ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, түүнд шинэ мэргэжил эзэмшүүлэх болон ажлын байрны баталгааг хангах;



- ажил, амралтын цагийн горим тогтоох;
- ажилтан, үүний дотор жирэмсэн, насанд хүрээгүй, тахир дутуу болон одой хүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах;
  - аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгжийг хувьчлах, өөрчлөн байгуулах тохиолдолд ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
  - үүнийн өсөлт, мөнгөний ханшийн бууралтын түвшнээс хамааруулж цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх;
  - ажилтны нийгмийн хамгаалалд зориулах хөрөнгийн хэмжээг тогтоох;
  - экологийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах;
  - ажиллахын зэрэгцээ суралцаж байгаа ажилтанд ажил олгогчийн зүгээс хөнгөлөлт үзүүлэх;
  - аж ахуйн нэгж, байгууллагын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, ясли, нийгэм, соёлын зориулалттай барилга, байгууламж барих, ашиглах, олон хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эх буюу ганц бие эцэг, тахир дутуу хүүхэдтэй ажилтанд хөнгөлөлт үзүүлэх, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан ахмад настан, тахир дутуу хүн, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс эрүүл мэнд нь хохирсон ажилтны амьжиргааг сайжруулах;
  - үйлдвэрчний эвлэл, түүний ажилтан, сонгуультаас үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоог хангах зэрэг болно.

Хамтын гэрээг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчин чухал юм. Барууны орнуудад хөдөлмөрийн харилцааны эрх зүйн нарийн зохицуулалт нь салбар, байгууллагын хүрээнд хамтын гэрээ байгуулах замаар асуудлыг шийддэгээрээ хөдөлмөрийн хуулиасаа илүү ач холбогдолтой болдог байна. Хамтын гэрээ байгуулах үйл

явц нь хамтын гэрээний нэгжийг тогтоох (гэрээ байгуулах эрх бүхий субъект); хэлэлцээрт оролцогч талууд харилцан бие биенээ хүлээн зөвшөөрсөн байх; талууд тавьж буй шаардлагуудаа тодорхойлж өгөх; хэлэлцээрийг зохих журмын дагуу явуулж, байгуулах; хамтын гэрээг хамт олноор хэлэлцүүлэн сайшаах; гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг үе шатуудаас бүрдэнэ.

Хамтын гэрээ хэлэлцээрийг зохион байгуулж, явуулах америк ба европын гэсэн хоёр загвар байна. Америк загвар нь юуны өмнө хэлэлцээр явуулах эрх бүхий нэгжийг тогтоох ба энэ эрхийг АНУ-ын Үндэсний хөдөлмөрийн харилцааг зохицуулах хороо нь хамт олны саналыг үндэслэн тодорхойлно. Хэлэлцээр хийх эрх бүхий нэгжид (үйлдвэрчний эвлэл эсвэл ажилтны төлөөлөл) тус хорооноос сертификат гардуулснаар уг гэрээг байгуулах эрх нь нээгдэнэ. Европ загвараар бол үйлдвэрчний эвлэлүүд дангаараа болон хамтарч ажил олгогчтой шууд хэлэлцээр хийдэг зарчим юм.

Гадаад орнуудын хуулийг судлахад дараахь зохицуулалтуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Франц, Япон, Грек, Итали, Испани, Португали зэрэг улсуудад хамтын гэрээг байгуулах эрхийг Үндсэн хуульдаа тусгасан байдаг. Герман, Австри, Дани, Люксембург зэрэг орнуудад ажилтны эвлэлдэн нэгдэх эрхийн салгаж үл болох эрх нь хамтын гэрээ байна гэжээ. Ихэнхи орнуудад хамтын гэрээ байгуулах асуудлыг хуулиар, зарим орнуудад зан заншил, шүүхийн жишиг, шүүхийн практик, мөн улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд байгуулагдах хамтын хэлэлцээрт тусгадаг байна.

- Мөн хамтын гэрээний үйлчлэх хүрээг ялгавартай тогтоосон байх жишээтэй. Тухайлбал АНУ, Боливид хөдөө аж ахуйн болон гэрийн ажилчдад хамаардаггүй. АНУ, Франци, Итали, Шинэ Зеланд, Япон зэрэг орнуудад төрийн албан хаагчдыг хязгаарлагдмал хүрээнд хамтын гэрээ байгуулахыг зөвшөөрдөг байна. (төрөөс шийдвэрлэх

асуудал, тухайлбал, цалин хөлсний асуудлыг тусгаж болохгүй). Зарим орнуудад төрийн банк, санхүүгийн байгууллага, Батлан хамгаалах яам, Цагдаагийн байгууллагын ажилтнууд гэрээ байгуулахыг хориглодог.

- Малайз, Сингапурын хуулинд шинээр байгуулагдсан компанийн хамтын гэрээнд өөр ажилд шилжүүлэх, ажлаас халах асуудлыг хязгаартайгаар тусгахыг заажээ.

- Сири, Ливи, Танзани зэрэг орнууд хамтын гэрээнд тусгагдсан асуудлууд нь улс орны эдийн засгийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл түүнийг бүртгэхгүй байх, зарим заалтыг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авдаг байна.

- Улс орнуудын онцлогоос шалтгаалан ажил олгогчийг хамтын гэрээ байгуулах хэлэлцээрийг шударгаар явуулах хэм хэмжээ тогтоосон боловч гэрээг заавал байгуулах үүрэг хүлээлгээгүй. Англид хувьчлагдсан салбарын байгууллагуудад хамтын гэрээг заавал байгуулахаар заажээ.

- АНУ, Испани, Португалид хамтын гэрээ байгуулах харилцаанд төрийн зохих байгууллага хяналт тавьдаг байна.

- Ажил олгогч гэрээ байгуулахад шаардлагатай мэдээллээр үйлдвэрчний эвлэлийг хангах үүрэгтэй байна.

- Хамтын гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны тухайд хамгийн багадаа 6 сар, дээд тал нь 5-6 жил байна. Практик дээр 1-2 жил байдаг байна.

- Заримт орнуудад (АНУ, Канад, Франц, Швед г.м) хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүх болон төрийн захиргааны байгууллагууд албадан биелүүлэх арга хэмжээ авдаг ба иргэний, захиргааны, эрүүгийн хариуцлага хүртэл хүлээлгэдэг байна.

- Европын орнууд, Япон, Австрали, Канад улсын Квебек-д хамтын гэрээг салбарын хэмжээнд заавал байгуулах, албадан биелүүлэх зохицуулалттай байдаг ба гэрээг хэвлэлд нийтэлж нийтийн хүртээл болгодог байна. Мөн, тухайлбал, Францад Хөдөлмөрийн яам,

Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч нар төрийн холбогдох албан тушаалтны удирдлаган дор байгуулдаг байна.

• АНУ, Канад, Шинэ Зеланд, Герман, Австри, Швед, Швейцар, Финлянд, Испани зэрэг орнуудад хамтын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд ажилт хаялт зохион байгуулахыг хуулиар хориглосон байна.

Олон улсын хэмжээнд “Дженерал Моторс” компаний “Сатурн” үйлдвэрийн хамтын гэрээг хүний нөөцийг зөв хуваарилж, үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгосноороо бусдад жишиг болсон хэмээн үздэг. Энэхүү гэрээнд үйлдвэрлэлийн конвейер аргаас татгалзах, харьцангуй бие даасан ажлын бригад байгуулах, ажил мэргэжил хослуулах, ажилчдад компаний хувьцааг эзэмших боломж олгох, улмаар ногдол ашиг хүртэх, ажилтны хөдөлмөрийн бүтээмж өндөр байх, шинэ бүтээл, оновчтой санал гаргах, шинэ мэргэжил, мэдлэг эзэмших зэрэгт материаллаг урамшуулал үзүүлэх, бонус олгох зэрэг асуудлуудыг тусгажээ. Түүнчлэн ажлын цагийн уян хатан систем, ажилчдыг үйлдвэрийн дотоод ажилд идвэхтэй оролцуулах (бүлгэм, зөвлөгөө өгөх хороод ажиллуулах г.м.), үйлдвэрийн ажилчдын 80%-д ажлын байрны баталгаа өгөх (ажилчдыг эдийн засгийн хямрал, үйлдвэрийн удирдлагаас урьдчилан таамаглах боломжгүй, тэдгээрээс үл шалтгаалах нөхцөл байдал үүсээн үед зөвхөн үйлдвэрчний эвлэлтэй зөвшилцсөний үндсэн дээр халах) зэрэг заалтуудыг оруулжээ.

Ийнхүү улс орнуудын хууль тогтоомжийг судлан үзэхэд хамтын гэрээ нь хуулиар зохицуулаагүй асуудлуудыг шийдвэрлэх, зөвхөн ажилтны бус мөн ажил олгогчийн эрх ашгийг хамгаалах, нийгэмд ажил эрхлэлтийг өргөн утгаар нь дэмжих, төрөөс хамтын гэрээ байгуулахыг бүх талаар дэмжин ажиллах, сурталчилах зэрэг ач холбогдолтой байна.

Манай орны тухайд эдийн засгийн хямралын үед бизнесийн байгууллагуудын ашиг буурах, компаниуд хоорондоо нэгдэх, нийлэх, хуваагдах, зарим тохиолдолд татан буугдах, дампуурах асуудлууд гарч байна. Энэхүү өөрчлөн байгуулагдах үйл ажиллагаанд тэнд ажиллаж буй хүмүүсийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Хэрэв эдгээр байгууллагууд нь ажилтны төлөөлөлтэй хамтын гэрээ байгуулсан байгаа бол эрх ашиг нь зөрчигдөхгүй гэх баталгаа байна.

МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн” бол 40.5-д зааснаар “ажил олгогч хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд нэг сарын өмнө мэдэгдэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажилтны төлөөлөгчдөд 45 хоногийн өмнө мэдэгдэж, энэ хуульд заасны дагуу хэлэлцээ хийнэ” гэжээ. Мөн 42.2-д “бөөнөөр халах үед ажил олгогч нь ажлаас халагдсаны тэтгэмжийн хэмжээг ажилтны төлөөлөгчидтэй хийсэн хэлэлцээгээр тохирч тогтооно” гэжээ. Эндээс үзэхэд бизнесийн байгууллагууд ажилтны төлөөлөлтэй хэлэлцээ хийх үү, хамгийн багадаа 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох уу, төрийн байгууллагуудын зүгээс үүнд хэрхэн хяналт тавих боломж байна, ер нь хяналт тавьж ажиллах сонирхол байна уу зэрэг олон асуудлууд урган гарч байна.

